

МАК
МОНГОЛЫН АЛТ
(МАК) ХХК

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛДАГ “НАРИЙН СУХАЙТЫН” НҮҮРСНИЙ УУРХАЙН 2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:
5458А, 12225А, 12226А, 6852А, 227А
Компанийн регистрийн дугаар 2095025

Хянасан:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
Хүрээлэн буй орчин, бодлого зохицуулалтын
газрын ахлах шинжээч

/Ц.Жаргалнэмэх /

Биелэлтийн тайлан гаргасан:

“Монголын Алт”(МАК) ХХК-ийн
Нарийн сухайтын уурхайн дарга


/А. Цолмонбаяр/

Нарийн Сухайтын уурхайн
Байгаль орчны мэргэжилтэн

/Э.Санжмаа/

Өмнөговь аймаг Гурвантэс сум
2023 он

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. “МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА.....	8
1.1 КОМПАНИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО	10
1.2 НАРИЙН СУХАЙТЫН УУРХАЙН ТАНИЛЦУУЛГА	10
1.3 НАРИЙН СУХАЙТЫН УУРХАЙН НҮҮРСНИЙ ОРД	12
1.4 ДЭД БҮТЭЦ, ЗАМ ХАРИЛЦАА, ЭРЧИМ ХҮЧ.....	12
1.5 УУРХАЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХҮЧИН ЧАДАЛ.....	13
1.6 АЖИЛЛАХ БОЛОВСОН ХҮЧНИЙ МЭДЭЭЛЭЛ	14
1.7 2023 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	15
БҮЛЭГ 2. НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР	16
2.1 ТЕХНОЛОГИЙН ПРОЦЕСС.....	16
2.2 НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН УСАН ХАНГАМЖ, УС ЗАРЦУУЛАЛТ	17
2.3 НҮҮРС ХУУРАЙ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР FGX.....	18
2.4 ТЕХНОЛОГИЙН ПРОЦЕСС.....	18
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	20
3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	20
3.2 ХӨРСНИЙ ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	21
3.3 УСНЫ НАЙРЛАГ, ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	22
3.4 УРГАМАЛ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	23
3.5 Хог хаягдлын нөлөөлөл.....	23
БҮЛЭГ 4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	24
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
5.1 АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ	25
5.1.1 <i>Зам талбайг услах, тоосжилт дарах.....</i>	25
5.1.2 <i>Зам талбайн тэмдэг тэмдэглэлээ нэмэгдүүлэх, хурдны хязгаарыг мөрдүүлэх.....</i>	27
5.1.3 <i>Нүүрсний машины бүтээлгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих</i>	29
5.1.4 <i>Шатах тослох материалын хадгалалтад хяналт тавих</i>	29
5.2 ХӨРСНИЙ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	32
5.2.1 <i>Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох, бүртгэл хөтлөх</i>	32
5.2.2 <i>Үржил шимт хөрсийг хуулж хэлбэржүүлэх</i>	33
5.2.3 <i>Шимт хөрсний чанар болон хөрсний мэдээллийг агуулсан самбар хийж байршуулах</i>	34
5.2.4 <i>Тогтсон маршрутын дагуу хөдөлгөөнд оролцох</i>	34
5.2.5 <i>Тосолгоо үйлчилгээг зориулалтын талбайд хийх.....</i>	35
5.2.6 <i>Хөрс хамгаалал, бохирдлоос сэргийлэх, арилгах талаар нийт ажилчдад сургалт явуулах.....</i>	36
5.2.7 <i>Хөрс саармагжуулах талбай хийх</i>	38
5.3 УСНЫ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ.....	39
5.3.1 <i>Уурхайн худгийн тоолууруудын заалтыг авч акт үйлдүүлэх</i>	39
5.3.2 <i>Унд ахуйн худгийн орчинд цэвэрлэгээ хийх</i>	40
5.3.3 <i>Усны нөөцийн савны ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.....</i>	41
5.3.4 <i>Булаг шандын орчимд цэвэрлэгээ хийх</i>	42
5.3.5 <i>Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах</i>	43
5.3.6 <i>НБҮ-ийн усны төлбөрийг ус ашиглах гэрээнд 327 дугаар тогтоолын дагуу тооцуулах</i>	45
5.3.7 <i>Уурхайн усны хэрэглээнд хяналт тавьж төлбөрийг тоолуурын заалтаар төлөх.....</i>	45
5.3.8 <i>Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх</i>	46
5.3.9 <i>Тайлант онд ашигласан усны хэмжээ</i>	47
<i>2016-2023 оны хооронд ашигласан усны хэмжээ</i>	48

5.4 Амьтан, ургамлыг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд	50
5.4.1 Амьтны судалгаа хийж гүйцэтгэх	50
5.4.2 Амьтдын тархалтын талаар мэдээллийн самбар уурхайн орчинд байршуулах	51
5.4.3 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	52
5.4.4 Зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авах	53
5.4.5 "Биологийн олон янз байдлыг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх	55
Ирвэс хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх	56
БҮЛЭГ 6 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	57
6.1 Уурхайн хавар, намрын мод тарилт	57
6.2 Мод үржүүлгийн талбайн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх	60
6.3 Хаалтын нөхөн сэргээлтийн санхүүгийн тооцоолол	61
6.4 Хоол, хүнсний хаягдал, тахианы сангасаар бордоо бэлтгэж нөхөн сэргээлтийн талбайд турших	64
6.5 Шимт хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх хадгалалтыг сайжруулах зорилгоор олон наст тарих	64
6.6 Хөрш зэргэлдээх уурхайнуудтай хамтран Гурвантэс сумын төвд байгуулсан цэцэрлэгт хүрээлэнг өргөжүүлэх ...	66
БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	68
7.1 Урт болон дунд хугацааны төлөвлөгөөтэй болж, шат дараалан арга хэмжээ авч ажиллах.....	68
БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..70	
БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	71
9.1 Нийт ажилчдад “САНАМСАРГҮЙ ОЛДВОРЫН ҮЕД АЖИЛЛАХ ЖУРАМ”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ СУРГАЛТЫГ ЯВУУЛАХ.....	71
9.2 Орон нутгийн хэмжээнд амьтан, ургамал, археологи, палеонтологи, түүхийн дурсгалын тухай танин мэдүүлэх зорилгоор самбар байршуулах, тараах материал хийх	72
9.3 Соёлын өвийг түгээн дэлгэрүүлж байгаа хүмүүсийг алдаршуулах	73
БҮЛЭГ 10 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ	75
10.1 Цэвэр усан хангамж, бохир усны шугам, түүний хамгаалалт, хаалтыг шалгаж бэлэн байлгах.....	75
10.2 Химийн бодистой хамааралтай ажилчдад химийн хортой болон аюултай бодисын тухай сургалт зохион байгуулах.....	75
10.3 Химийн бодистой харьцаж ажилладаг ажилчдыг хамгаалах хувцас хэрэгслээр бүрэн хангах	76
10.4 Химийн бодисын бүртгэлийг сар бүр хийж заавар зөвлөгөө өгч байх	76
10.5 Уурхайн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг сайжруулах	77
10.6 Хаягдал тосны агуулах дүүрэхэд гэрээт компанид хүлээлгэн өгч зориулалтын машинд ачиж өгөх	79
10.7 Шатах тослох материалын болон хаягдлыг түр хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж бэлтгэх, асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгах	79
БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	80
11.1 Ахуйн хог хаягдал гаргасны төлбөрийн гэрээг хийж төлбөрийг төлөх.....	80
11.2 Уурхайн орчны хог хаягдлын цэвэрлэгээ хийх хуваарь гарган батлуулж цэвэрлэгээг хийх	81
11.3 Хог хаягдлыг "Шугшаа Уул" ОНӨААТҮГ-ААР УСТГУУЛАХ.....	82
11.4 Химийн бодисын сав баглаа боодлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах.....	83
11.5 Эмнэлгийн хог хаягдлыг Гурвантэс сумын эмнэлэгтэй гэрээ хийж устгуулах	85
11.6 Хаягдал тосыг мэргэжлийн байгууллагаар устгуулах	86
11.7 Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах боловсруулах талаар сургалт орж шинэлэг санааг гаргаж хэрэгжүүлэх	88
БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	93
12.1 Нарийн сухайтын бүлэг ордод үйл ажиллагаа явуулж байгаа уурхайнуудтай хамтран мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх.....	95
12.1.1 Агаарын найрлага, тоосжилт	95

12.1.2 Усны мониторинг хийх.....	97
12.1.3 Хөрсийн ерөнхий үзүүлэлтүүд.....	108
12.1.4 Ургамлын гарц, ургац, төрөл зүйл, бүлгэмдэл, ховор ургамал зэргийг судлах, мониторинг хийх.....	110
12.1.5 Амьтны аймаг анхан шатны мэдээлэл цуглуулах, амьтны төрөл зүйлийг бүртгэх.....	111
БҮЛЭГ 13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨГӨӨ.....	114
13.1 Байгаль орчны төлөвлөгөөт аудит гүйцэтгүүлэх.....	114
13.2 Байгаль орчны хуулийг хэрэгжүүлэх, төрийн байгууллагуудтай хууль эрх зүйн зөвшөөрөл авах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд.....	116
13.3 Байгаль орчны чиглэлийн орон нутгийн ТББ-ууд, иргэдтэй хамтран ажиллах.....	118
13.4 Уурхайн тухайн оны БОМТ-нд заагдсан ажлуудыг сарын, улирлын төлөвлөгөөнд оруулан батлуулах.....	119
13.5 Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлэх.....	120
13.6 Сумын байгаль орчны чиглэлээр ажил хийдэг айл өрхөөр орж ажилтай танилцах.....	120
13.7 ХҮЛЭМЖИЙН ХИЙН ТАЛААР АЖИЛЧДАД ОЙЛГОЛТ ТҮГЭЭХ, ДАТА БҮРТГЭХ.....	120
БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	122
14.1 Гурвантэс сумын иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, Гурвантэс сумын ИНХ-д тайлан танилцуулах.....	122
14.2 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг танилцуулж, дүгнүүлэх.....	124
БҮЛЭГ 15. АЙМАГ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ.....	124
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮГНЭЛТ.....	126

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Түүхэн замнал.....	8
Зураг 2. “Монголын Алт” (МАК) ХХК-ийн бусад төслүүд	10
Зураг 3 Нүүрс олборлолт	11
Зураг 4. Нарийн Сухайтын уурхайн засвар үйлчилгээний төв	11
Зураг 5. Нарийн сухайтын уурхайн байршил	12
Зураг 6. Уулын ажлын техник тоног төхөөрөмжүүд.....	14
Зураг 7. Орон нутгаас ажиллаж байгаа ажилтны мэдээлэл	15
Зураг 8. 2023 оны ашиглалтын өнөөгийн байдал	15
Зураг 9. Нүүрс нойтон баяжуулах үйлдвэр	16
Зураг 10. Нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн схем	17
Зураг 11. Ил уурхайн үерийн ус болон усан сан	18
Зураг 12. Тоног төхөөрөмж холболтын схем.....	19
Зураг 13. Байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг харуулсан бүдүүвч зураг	20
Зураг 14. Уурхай орчмын хөрсний эвдрэлийн төлөв байдал.....	22
Зураг 15. Зам талбайн тоосжилт дарахад ашигласан усны хэмжээ, сараар	25
Зураг 16. Уурхайн карьер болон зам талбайн тоосжилт дарах усалгаа.....	26
Зураг 17. Зам усалгааны бороожуулагч систем	26
Зураг 18. Уурхайн бүсэд тээврийн хэрэгсэл жолоодох, түр үнэмлэх ашиглах журам	27
Зураг 19. Замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулж байгаа байдал.....	27
Зураг 20. Гайхам системийн хяналтын зураг	28
Зураг 21. Гайхам системийг хүлээн авсан акт	28
Зураг 22. Хучлагын талбайд ажиллах журам.....	29
Зураг 23. Уурхайн ШТС, тосны агуулах	30
Зураг 24. Үзлэг шалгалт хийх төлөвлөгөө болон албан даалгавар өгсөн байдал хариу ирүүлсэн талаар	31
Зураг 25. Газар хөндөх зөвшөөрөл авсан байдал.....	33
Зураг 26. Шимт хөрсний овоолгын байршил.....	34
Зураг 27. 4-р шимт хөрсөнд байршуулсан самбар.....	34
Зураг 28. Уурхайд ашиглаж байгаа зам талбайн ерөнхий зураг	35
Зураг 29. Бетондсон засварын талбай болон засварын зориулалтын талбай.....	35
Зураг 30. ЗҮТ-ийн техник засварын талбайн зураг	36
Зураг 31. Хаягдал тос хадгалах сав, технологийн зураг	36
Зураг 32. Сургалт орж буй байдал	37
Зураг 33. Сургалтын баталгаажуулалт гарын үсэг	38
Зураг 34. Геомембран	38
Зураг 35. Хөрс саармагжуулах талбайн төлөвлөгөө.....	39
Зураг 36. Орчны цэвэрлэгээ хийх батлагдсан төлөвлөгөө.....	40
Зураг 37. Орчны цэвэрлэгээ хийх байгаа байдал.....	40
Зураг 38. Ариутгал халдваргүйтгэл хийлгэх гэрээ байгуулсан байдал .. Error! Bookmark not defined.	
Зураг 39. Усны нөөцийн саванд ариутгал хийлгэсэн байдал	41
Зураг 40. Усны нөөцийн саванд ариутгал хийсэн акт	42
Зураг 41. Булаг шандын ойр орчмыг цэвэрлэсэн зураг.....	43
Зураг 42. Усны сургалт	43
Зураг 43. Усны сургалт орсон ажилчдын баталгаажуулах гарын үсэг зурсан байдал.....	44
Зураг 44. Сургалт орж буй болон стикер байрлуулж буй байдал	44
Зураг 45. Баяжуулах үйлдвэрийн усны төлбөрийн баримт	45
Зураг 46. Усны төлбөр төлсөн баримт.....	45
Зураг 47. Шагналт байр эзэлсэн сурагчид.....	46
Зураг 48. Тэмцээн зохион байгуулал удирдамж	47
Зураг 49. Нийт ашигласан усны хэмжээ, тн	48
Зураг 50. Ус ашиглалт 2016-2023 оны харьцуулалт.....	49
Зураг 51. Судалгааны үед тааралдсан амьтдын байршил.....	51

Зураг 52. Амьтны мэдээллийн самбар	51
Зураг 53. Ногоон байгууламжийн өнөөгийн байдал	52
Зураг 54. Зүлэг усалгааны систем	52
Зураг 55. Ажилчдын хотхонд тарьсан мандалын цэцэг	53
Зураг 56. Өвс ачиж байгаа байдал.....	54
Зураг 57. Хүлээлгэн өгсөн акт, зураг	56
Зураг 58. Байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаанд дуран хүлээлгэн өгсөн байдал	56
Зураг 59. Уурхайн ногоон байгууламж	57
Зураг 60. Мод үржүүлгийн талбай болон уурхайн бусад байршилд мод тарьсан байдал	59
Зураг 61. Мод тарих аянд нэгдсэн гэрээт байгууллагад гэрчилгээ олгосон	59
Зураг 62. Зуны хүлэмжид тарилт хийж буй байдал.....	60
Зураг 63. Гэрээт компанийн төлөвлөгөө	61
Зураг 64 . Нөхөн сэргээлтийн санхүүгийн тооцоолол мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн гэрээ ..	62
Зураг 65. Ажлын явц болон урьдчилсан байдлаар гаргасан нийт эвдэрсэн газрын тоо	62
Зураг 66. Хөрсний овоолгыг тооцооллыг дагуу техникийн нөхөн сэргээлт хийсний дараах байдал ..	63
Зураг 67. Хөрсний овоолгыг тооцооллыг дагуу техникийн нөхөн сэргээлт хийсний дараах байдал ..	63
Зураг 68. Компост бордоо бэлтгэх үйл явц	64
Зураг 69. Шимт хөрсний №4 овоолгод хийх ажлын батлагдсан төлөвлөгөө	65
Зураг 70. Төлөвлөгөөний дагуу хэлбэржүүлж, зүлэг тарьсан байдал	66
Зураг 71 . Цэцэрлэгт хүрээлэнгийн гэрээ, зураг төсөл.....	67
Зураг 72. Тохижилтын ажил гүйцэтгэж буй байдал.....	67
Зураг 73. БОННУ-ний дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө	68
Зураг 74. Батлагдсан ажлын даалгавар, гүйцэтгэгч байгууллагатай хийсэн гэрээ.....	69
Зураг 75. Нөлөөллийн бүсийн айлтай байгуулсан нүүлгэн шилжүүлж нөхөн олговор олгох гэрээ, нөхөн олговрын баримт	70
Зураг 76. Худалдан авч өгсөн газрын кадастр	70
Зураг 77. Санамсаргүй олдворын үед ажиллах журмын сургалт.....	71
Зураг 78. ШУА-д судалгаа хийлгэхээр гаргасан хүсэлт, судалгааны ажлын дүгнэлт, тайлан.....	72
Зураг 79. Гурвантэс сумын төвд байршуулсан самбар	72
Зураг 80. Палеонтологийн ном, тараах материал хүлээлгэн өгсөн байдал	73
Зураг 81. Соёлын өвийг түгээн дэлгэрүүлсэн иргэдийг урамшуулсан байдал	74
Зураг 82. Үзлэг шалгалт хийх хуваарь	75
Зураг 83. Сургалт орж байгаа байдал	76
Зураг 84. Тусгай хамгаалах хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас	76
Зураг 85. Цэвэрлэх байгууламжийн ажлын гэрээ, суурилуулалтын явц.....	78
Зураг 86. Цэвэрлэх байгууламжаас модны усалгаанд татсан систем	79
Зураг 87. Хаягдал тос хүлээлгэн өгсөн акт, бүртгэл	79
Зураг 88. Асгаралтын иж бүрдэл.....	80
Зураг 89. Хог хаягдал гаргасны төлбөр	80
Зураг 90. Нийтийн цэвэрлэгээ хийх батлагдсан хуваарь	81
Зураг 91. Нийтийн цэвэрлэгээ хийж байгаа байдал	82
Зураг 92. Хог хаягдал устгуулах гэрээ болон ачуулсан байдал	83
Зураг 93. Нүүрс баяжуулах үйлдвэрийн химийн бодисын агуулах.....	84
Зураг 94. Баяжуулах үйлдвэрийн химийн бодисын сав боодлыг хүлээлгэж өгсөн акт	84
Зураг 95. Аюултай хаягдлын бүртгэлийн дэвтэр болон түр хадгалах шүүгээ.....	85
Зураг 96. Эмнэлгийг тусгай хог хаягдал устгуулах гэрээ, хаягдал нийлүүлсэн бүртгэл.....	86
Зураг 97. Монпити Ойл ХХК-тай байгуулсан гэрээ, аюултай хог хаягдлын дагалдах хуудас.....	87
Зураг 98. Хаягдал тосны ачилтын үеийн зураг	87
Зураг 99. Хаягдал поошигний дагалдах бичиг болон ачилт хийж байх үеийн зураг.....	88
Зураг 100. Хог хаягдлын батлагдсан журам, хуваарь	88
Зураг 101. Аюултай хог хаягдлын бүртгэлийн дугаар.....	89
Зураг 102. ОХШХ-ийн батлагдсан төлөвлөгөө, хуваарь	93
Зураг 103. Хэмжилт хийх батлагдсан цэгүүд.....	94
Зураг 104. Орчны хяналт шинжилгээний ажлыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх гэрээ	95

Зураг 105. Уурхайн орчинд хийсэн РМ 10 тоосны хэмжилтийн үр дүн	95
Зураг 106. Уурхайн орчимд хийсэн РМ 2,5 тоосны хэмжилтийн үр дүн	96
Зураг 107. Агаарын тоосжилт хэмжиж буй байдал	96
Зураг 108. Нөлөөллийн бүс дэх гар худгуудын усны түвшний хэмжилт	97
Зураг 109. Худаг, цооногийн байршлын зураг	98
Зураг 110. Нөлөөллийн бүсэд хамаарах гар худгууд	100
Зураг 111. Уурхайн бүсийн усны шинжилгээ	101
Зураг 112. Цооногт хэмжилт хийж байгаа байдал	101
Зураг 113. Иргэдтэй хамтарсан арга хэмжээ	102
Зураг 114. Балансыг олох процедур	105
Зураг 115. Оролт гаралтын схем	107
Зураг 116. Худгийн байрны зураг	107
Зураг 117. Шинээр байршуулсан эко нойл болон, хуучин нүхэн жорлонгийн акт	110
Зураг 118. Амьтны мониторингийн зураг	111
Зураг 119. Судалгааны үед таарсан амьтдын тархалтын зураг	112
Зураг 120. Судалгааны үед тааралдсан амьтдын зураг	113
Зураг 121. Байгаль орчны аудитын гэрээ	114
Зураг 122. 2023 оны Хөндлөнгийн төлөвлөгөөт аудитын зөвлөмж, дүгнэлт	114
Зураг 123. Сургалт семинарт хамрагдах ажлын удирдамж	115
Зураг 124. Мод тарьж хашиж хамгаалсан байдал	116
Зураг 125. Дуслын усалгааны систем мод услагдаж буй байдал	116
Зураг 126. БОННУ-ийн танилцуулга	117
Зураг 127. Элс хайрга хүссэн хүсэлт, төлбөрийн баримт	117
Зураг 128. Мод үржүүлгийн газруудтай танилцах өдөрлөг	118
Зураг 129. Туршлага солилцох аяллын баг	118
Зураг 130. НСУ-н үйл ажиллагааны төлөвлөгөө болон БЗД-ийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	119
Зураг 131. Баруун Сухантын өрхийн мод үржүүлгийн талбай	120
Зураг 132. Техникүүд, оффисын орчинд стикер нааж буй байдал	121
Зураг 133. Хүлэмжийн хийн сургалтын материал, эх үүсвэрүүд	122
Зураг 134. Сургалт орж буй процесс	122
Зураг 135. Ил тод хариуцлагатай уул уурхай, Гурвантэс сумын ИНХ	123
Зураг 136. Хэлэлцүүлэгт оролцсон зураг	123
Зураг 137. БОМТ-ын тайлан танилцуулсан байдал	124
Зураг 138. Зам засаж байгаа үеийн зураг тайлан	125
Зураг 139. Тоннын сав авах хүсэлт, хүлээлгэн өгсөн байдал	126

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Уурхайд ашиглагдах техник, тоног төхөөрөмж.....	13
Хүснэгт 2. 2023 оны уулын ажлын гүйцэтгэл.....	15
Хүснэгт 3. Материалын баланс	17
Хүснэгт 4. Уурхайн үерийн усны хэмжээ	17
Хүснэгт 5. Материалын баланс	19
Хүснэгт 6. Нүүрсний ил уурхайгаас үүсэх тоосонцрын хаягдал	21
Хүснэгт 7. Зам усалгааны машины усны хэмжээ болон рейсийн тоо	25
Хүснэгт 8. Уурхайн орчинд мөрдөж байгаа хурдны хязгаар	27
Хүснэгт 9. Ажлын байрны үзлэг шалгалт зөрчил	30
Хүснэгт 10. 2023 оны хөндөгдсөн газрын хэмжээ га, 10 сар.....	32
Хүснэгт 11. 2023 онд хуулж хэлбэржүүлсэн шимт хөрсний овоолгын дугаар, хэмжээ	33
Хүснэгт 12. Хөрсний бохирдлын сургалт	36
Хүснэгт 13. Уурхайд ашиглаж байгаа баталгаажсан тоолуурын мэдээлэл.....	39
Хүснэгт 14. Усны хэрэглээ, зориулалт эхний 10 сарын байдлаар	47
Хүснэгт 15. Тухайн жилийн ус ашиглалтыг ус ашиглах дүгнэлттэй харьцуулсан байдал, 2016-2023 он	48
Хүснэгт 16. Усны бичиг баримтын бүрдэл	49
Хүснэгт 17. Судалгааны үед тааралдсан амьтны байршил, тоо толгой	50
Хүснэгт 18. Ногоон байгууламжийн тооллого	52
Хүснэгт 19. 2023 онд нөхөн тарилт хийсэн модны төрөл, тоо хэмжээ	53
Хүснэгт 20. Биотехникийн арга хэмжээнд нийт зарцуулсан зардал.....	55
Хүснэгт 21. 2023 оны мод тарилтын байршил, мэдээлэл	57
Хүснэгт 22. Химийн бодисын зарцуулалт.....	77
Хүснэгт 23. Шинээр барьсан цэвэрлэх байгууламжийн хүчин чадал	77
Хүснэгт 24. Нийтийн цэвэрлэгээ хийх үед гарсан хог хаягдлын хэмжээ.....	81
Хүснэгт 25. Ахуйн хог хаягдал гэрээний дагуу устгуулсан байдал	83
Хүснэгт 26. Аюултай хаягдал устгуулах хэмжээ	85
Хүснэгт 27. Эмнэлгийн хог хаягдал устгуулсан бүртгэл.....	85
Хүснэгт 28. Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг дахин ашигласан бүртгэл.....	92
Хүснэгт 29. Судалгаа хийж байгаа давтамж, цэгийн тоо	94
Хүснэгт 30. Усны түвшний хэмжилт	97
Хүснэгт 31. Нөлөөллийн бүсэд байрлах гар худгуудын ерөнхий химийн шинжилгээний дүн.....	99
Хүснэгт 32. Уурхайн бүсийн усны ерөнхий химийн шинжилгээний дүн.....	99
Хүснэгт 33. Нөлөөллийн бүсийн усны хүнд металлын шинжилгээний дүн.....	100
Хүснэгт 34. Усны түвшний хэмжилт	103
Хүснэгт 35. Уурхайд орж ирэх усны хэмжээ	104
Хүснэгт 36. Усны оролт	106
Хүснэгт 37. Усны гаралт	106
Хүснэгт 38. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн.....	108
Хүснэгт 39. Хөрсний физик, хими шинж чанар	108
Хүснэгт 40. Хөрсний үзүүлэлт	109
Хүснэгт 41. Судалгааны үед тааралдсан амьтны бүртгэл.....	111
Хүснэгт 42. БОМТ-ын хүрээнд хандив тусламж үзүүлсэн байдал	120
Хүснэгт 43. Нэмэлтээр хийсэн ажлын хүрээнд орон нутгийн төрийн байгууллагуудад уурхайн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах арга хэмжээний талаар танилцуулсан байдал	124
Хүснэгт 44. БОМТ-г хэрэгжүүлэхэд гарсан зардал.....	127

БҮЛЭГ 1. “МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

"Монголын Алт"(МАК) ХХК барилгын материалын үйлдвэрлэл, уул уурхай, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Үүний зэрэгцээ байгаль орчинд сөрөг нөлөөгүй, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, бид дэлхийн жишигт нийцсэн техник технологи, арга туршлагаар барилгын гол түүхий эд, материалуудыг үйлдвэрлэн импортын хараат байдлыг арилган нийт 3,000 гаруй баялаг бүтээгчийг ажлын байраар хангаж байна. 1993 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш нийт 2.1 их наяд төгрөгийг улс, орон нутгийн төсөвт татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлээд байна. Мөн Монгол улсын Засгийн газар, МҮХАҮТ хамтран жил бүр шалгаруулдаг Монгол улсын Топ-100 аж ахуйн нэгжийн жагсаалтад 22 дахь жилдээ тасралтгүй эрэмбэлэгдээд байна.

1993 онд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаагаа эхэлж, үндэсний хөрөнгө оруулалттай Монгол улсын тэргүүлэх аж ахуйн нэгж болох гараагаа тавьсан. XX зууны Монгол улсын хөгжлийг түргэсгэх гол салбаруудын нэг болох уул уурхайн салбарыг түшиглэн хөгжих боломжийг тухайн үед олж харан алсын хараагаа тодорхойлсон эхний 10 жил бол түүхэн цаг хугацаа байлаа.

Эх орныхоо байгалийн баялгийг мэргэжлийн түвшинд судлан шинжилж, тодорхой нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар “Монгол улс - Үйлдвэрлэгч орон-Хөгжил” гэсэн үндсэн зорилгыг өмнөө тавьж, амжилтаа ахиулсан удаах 10 жил байлаа.

Дээрх зорилгын хүрээнд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, байгаль орчин, бүс нутгийн хөгжил, хүн амын эрүүл мэнд, боловсролд хөрөнгө оруулалт хийх, цаашлаад үндэсний компанийн хувьд Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулах нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж ирлээ.

Уул уурхайн салбарт боловсруулах үе шатнаас эцсийн бүтээгдэхүүний хүртэлх чиглэл бий болгон, олон тулгуурт эдийн засгийн хөгжлийг эх орондоо цогцлоох их бүтээн байгуулалтын үеийг эхлүүллээ.



Зураг 1. Түүхэн замнал

Дэлхийн шилдэг техник технологи бүхий “Хийт бетоны үйлдвэр”, “МАК Цемент - Шохойн үйлдвэр”, “Цонх хаалганы үйлдвэр”, “Бетон хийцийн үйлдвэр” зэрэг үйлдвэрүүдийг ашиглалтад оруулснаар импортын хараат байдлыг зогсоож, барилгын салбарт хөгжлийн шинэ эрин үеийг эхлүүллээ.

Монгол хүн эх орондоо ажиллах, өөрийн эзэмшсэн мэргэжил, ур чадвараар бахархах, цаашид хөгжин дэвших хүсэл эрмэлзлийг дэмжих таатай нөхцөлийг бий болгон ажиллаж байна. Геологи хайгуул, уул уурхай, барилгын материал үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгө, аялал жуулчлал агаарын тээвэр, хөдөө аж ахуй, зам, барилга угсралтын чиглэлээр Монголын мянга мянган залуус

нэг зорилго, нэг хүсэл тэмүүлээр нэгдэн ажиллаж , үндэсний тэргүүлэгч компанийг бий болгон улс орны цаашдын хөгжлийн замыг түүчээлсэн он жилүүд үргэлжилж байна.

Эрдэнэс Цагаан Суварга ХХК



Нарийн Сухайтын уурхай



Хүрэн Толгой Коал Майнинг ХХК




МАК Евро Венти



МАК Евро Виндоор



МАК Евро Цемент



МАК Евро Блок



Зураг 2. “Монголын Алт” (МАК) ХХК-ийн бусад төслүүд

1.1 КОМПАНИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

Бидний эрхэм зорилго: Компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд байгаль орчинд үүсэж болох аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг хамгийн бага байлгах талаар анхааран ажиллах нь компанийн нийт ажиллагсдын нэн тэргүүний зорилт болно.

Бидний дээдлэх үнэт зүйлс: Компани ба түүний салбар нэгжүүд нь үйлдвэр, уурхайн төслийг боловсруулах шатнаас үйл ажиллагааныхаа бүх хүрээнд байгаль орчны асуудлыг байнга анхаарч Монгол улсын байгаль орчны хууль, дүрэм, журам болон олон улсын хэмжээнд мөрдөж буй уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөнө. Эх орон, төрсөн нутаг, усаа хайрлан хамгаалах нь компанийн бүх ажилчид албан хаагчдын үнэт зүйл билээ.

1.2 НАРИЙН СУХАЙТЫН УУРХАЙН ТАНИЛЦУУЛГА


“Монголын Алт” (МАК) ХХК нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Нарийн Сухайтын ордод 2007 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Тус уурхай нь ашиглалтад орсон цагаасаа хойш улс, орон нутгийн төсөвт 1.3 их наяд төгрөгийг төвлөрүүлээд байна. 2018 онд

Монгол улсад анх удаа гурван бүтээгдэхүүн гидроциклон бүхий дэвшилтэт технологийг ашиглан жилд нэг сая тонн нүүрс баяжуулах хүчин чадал бүхий үйлдвэр ашиглалтад оруулсан.




Зураг 3 Нүүрс олборлолт

“Монголын Алт” (МАК) ХХК нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэр дахь Нарийн Сухайтын уурхайн ажлыг эхлүүлснээс хойш 15 жилийн хугацаанд 37.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах, ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих, соёлын өвийг хамгаалах зэрэг ажилд зарцуулаад байна.



Зураг 4. Нарийн Сухайтын уурхайн засвар үйлчилгээний төв



Зураг 5. Нарийн сухайтын уурхайн байршил

1.3 НАРИЙН СУХАЙТЫН УУРХАЙН НҮҮРСНИЙ ОРД

Нарийн сухайтын уурхай нь 2007 оны 12 дугаар сарын 11-нд анхны хөрс хуулалт хийж, 2008 оны 05 дугаар сарын 30-нд анхны нүүрс экспортыг хийсэн. Нийт 1162 га талбай бүхий 227А, 5458А, 6852А, 12225А, 12226А, тоот ашиглалтын 5 тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

Ордын нөөцийг 11 км хүртэл сунасан 8 давхраанд (V, VI, VII, VIII, IX, X, XI, XII гэсэн дугаартай), гадаргын 1530-1550 м-ийн үнэмлэхүй түвшнээс доош 937-1060 м үнэмлэхүй түвшин хүртэл 500-600 м-ийн гүнд А+В+С+F1 зэргээр бодсон бол үүнээс 300 м хүртэлх гүнд А+В+С зэргээр бодсон байна. Нөөц, баялгийг эдийн засгийн үр ашигтай, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай хэмээн ангилж бодсон бөгөөд үүнээс А+В+С зэргээр эдийн засгийн үр ашигтай 496.7 сая.тн нүүрсний нөөцийг тодорхойлсон.

1.4 ДЭД БҮТЭЦ, ЗАМ ХАРИЛЦАА, ЭРЧИМ ХҮЧ

Дэд бүтэц: Гурвантэс сум нь манай орны хамгийн өмнөд захын сум бөгөөд хойд ба баруун талаараа Баянхонгор аймгийн Баянлиг, Баянговь, Шинэжинст сумуудтай, зүүн талаараа аймгийнхаа Сэврэй, Ноён сумуудтай, урд талаараа ӨМӨЗО-ны Эзнээ хошуутай тус тус хиллэдэг.

2007 онд Гурвантэс суманд Mobicom, 2008 онд Овоотын цэргийн ангид Skytel, 2009 онд “Монголын Алт” (МАК) ХХК-ийн уурхайн тосгонд Mobicom-ийн сүлжээ тавигдсанаар тус орон нутагт мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ сайжирсан.

Зам харилцаа: Шивээ хүрэн боомтоос уурхай хүртэл нүүрс тээврийг бетон замаар 2015.06.19-ний өдрөөс эхлэн тээвэрлэж эхэлсэн. Бетон зам ашиглалтад орсноор тоосжилт эрс буурсан, тээвэрлэлтийн цаг хугацаа хэмнэсэн, хог хаягдал шатах тослох материалын бохирдол харьцангуй багасах, замаас бусад талбайд хөрсний эвдрэл гэмтэл арилах, олон салаа зам үүсэхгүй байх зэрэг давуу талуудтай байна. Аймаг сумын төвүүдтэй ердийн шороон замаар холбогддог.

2010 оны 8 сард “Чинхуа-МАК-Нарийн сухайт” ХХК нь Монгол Улсын хилээс өөрийн уурхайн тосгон мөн “Монголын Алт” (МАК) ХХК-ийн уурхайн тосгон, тэдгээрийн хоорондын авто замыг хатуу хучилттай болгосон.

Эрчим хүч: Хилийн боомтыг дайруулан БНХАУ–ас 70 км урттай 35кВ–ийн өндөр хүчдэлийн шугамтай. Овоотын хилийн цэргийн 0166-р анги, Гурвантэс сум руу цахилгаан дамжуулах шугам татаж дэд станц барьснаар цахилгаан эрчим хүчний байнгын эх үүсвэртэй болсон.


1.5 Уурхайн тоног төхөөрөмжийн хүчин чадал

Нарийн сухайтын уурхай нь АНУ, Беларус, Герман, Япон, Хятад зэрэг улсуудад үйлдвэрлэгдсэн 10 төрлийн нийт 202 ширхэг техник хэрэгслүүдийг ашиглаж байна. 2023 онд уурхайн үйл ажиллагаанд ашигласан 118 ширхэг техник тоног төхөөрөмжийн жагсаалтыг (Хүснэгт 1)-д үзүүлэв.

Хүснэгт 1. Уурхайд ашиглагдах техник, тоног төхөөрөмж

№	Зориулалт	Техник, тоног төхөөрөмж	Хүчин чадал	2023 онд ашигласан техник
1	Нүүрс олборлолт	Экскаватор CAT 390	5.4-6 м3	4
2		Экскаватор CAT 395	6.5 м3	2
4		Экскаватор Hyundai 500	3.2 м3	3
5		Хово автосамосвал	60 тн	10
6	Хөрс хуулалт	Экскаватор ЭКГ-10 УНИ	10 м3	1
7		Экскаватор RH 170	20-22м3	3
8		Экскаватор RH 120	15 м3	2
9	Өрмийн машин	Сэндвик D75KS	250 мм	2
10		Сэндвик D45KS	229 мм	4
11		Atlas copco DML	229 мм	3
12	Утгуурт ачигч	CAT 988H	7,7 м3	2
13		CAT 988H	13 м3	2
14		LW 1200 XMG	8 м3	7
15	Овоолго зам талбайн техникүүд	CAT D10R	18 м3	6
16		CAT 834H	18 м3	2
17		CAT 844H	24 м3	1
18		Автогрейдер CAT 16M	221 кВт	3
19	Нүүрс олборлолт	БелАЗ 75131	130 тн	12
20		CAT-777	110 тн	7

21	Хөрс тээвэр	БелАЗ 75306	220 тн	38
23	Зам талбайн усалгаа	БелАЗ 76473	30 м3	4
Нийт				118



Зураг 6. Уулын ажлын техник тоног төхөөрөмжүүд

1.6 АЖИЛЛАХ БОЛОВСОН ХҮЧНИЙ МЭДЭЭЛЭЛ

Нарийн сухайтын уурхайн 2023 оны бүтэц, орон тоо 1351 орон тоогоор батлагдсан болно. 2023 онд 1148 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Өмнөговь аймгаас 219 ажилтан, үүний 125 ажилтан Гурвантэс сумаас тус тус ажиллаж байна. Нийт ажилтны 19%-ийг Өмнөговь аймгийн харьяатай иргэд бүрдүүлж байна.




Зураг 7. Орон нутгаас ажиллаж байгаа ажилтны мэдээлэл

1.7 2023 оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга

2023 онд 12225А лицензийн талбайд уулын ажлыг явуулсан. Уулын ажилд нийт 23 төрлийн 118 техник тоног төхөөрөмж 7/24 цагийн хувиараа ажиллаж нийт уулын ажлын биелэлт 97%-тай явж байна.

Хүснэгт 2. 2023 оны уулын ажлын гүйцэтгэл

№	Уулын ажлын үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны төлөвлөгөө гүйцэтгэлийн харьцуулалт		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт, %
1	Өрөмдлөг	т.метр	369,175	358,330	97%
2	Тэсэлгээ	м3	11,711,536	10,666,699	91%
3	Хөрс хуулалт	м3	11,942,166	11,635,924	97%
4	Нүүрс олборлолт	тн	4,009,334	3,684,223	92%
5	Нүүрс борлуулалт	тн	4,802,926	4,787,448	100%
6	Нийт уулын цул	м3	14,847,481	14,305,651	96%
Нийт уулын ажил		м3	16,538,849	16,058,157	97%



Зураг 8. 2023 оны ашиглалтын өнөөгийн байдал

БҮЛЭГ 2. НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР

Нойтон баяжуулах үйлдвэр нь цагт 170 тонн, жилд 1 сая тонн тэжээлийн нүүрсийг боловсруулах хүчин чадалтай модуляр үйлдвэр юм. Баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж нь дараах үндсэн хэсгүүдтэй. Үүнд:

1. Нүүрс хүлээн авах бункер
2. Бутлан тээвэрлэх хэсэг
3. Баяжуулах төв корпус
4. Баяжмал, завсрын бүтээгдэхүүн, хаягдал тээвэрлэх хэсэг
5. Уурын зуух
6. Усан сан, насос станц
7. Химийн бодисын агуулах
8. Дэд станц
9. Оффис




Зураг 9. Нүүрс нойтон баяжуулах үйлдвэр

2.1 ТЕХНОЛОГИЙН ПРОЦЕСС

Нүүрс баяжуулах үйлдвэрийн тэжээл нь дунджаар 25% хүртэлх үнслэгтэй 1 сая тонн тэжээлийн нүүрс байна.

Жилд 170 тонн.цаг хүчин чадлаар 6000 цаг ажиллаж 73.16%-ийн гарц бүхий нийт 731.6 мян.тонн 5.37%-ийн үнслэгтэй баяжмал үйлдвэрлэн борлуулдаг. 3.57%-ийн гарцтай 35.7 мян.тонн завсрын бүтээгдэхүүн болон 23.27%-ийн гарц бүхий 232.7 мян.тонн хаягдлыг зөвшөөрөл авсан овоолгын талбайд хадгална.



Зураг 10. Нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн схем

Хүснэгт 3. Материалын баланс

Бүтээгдэхүүн	Гарц, %	Гарц, тн	Ash, %	Чийг, %	St, %
Баяжмал	73.16	124.37	5.37	8.16	0.73
Завсрын бүтээгдэхүүн	3.57	6.07	61.79	13.71	2.39
Баяжмал + Завсрын бүтээгдэхүүн	76.73	130.45	8.0	8.43	0.8
Том хаягдал	21.77	37.0	83.73	14.22	1.81
Нунтаг хаягдал	1.50	2.55	5.37	24.0	2.35
Тэжээл	100.0	170.0	25.0	4.0	1.05

2.2 НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН УСАН ХАНГАМЖ, УС ЗАРЦУУЛАЛТ

Үйлдвэр жилд бүрэн хүчин чадлаар ажиллах үед технологийн процесст хамгийн ихдээ жилд $\approx 100,000$ м³ (4-5 л/сек) ус ашиглана. Дээрх хэмжээний усыг ил уурхайн шүүрлийн болон үерийн усаар 10-15 жил хангах бүрэн боломжтой. Зүүн уурхайд 2 хэсэг газарт тогтсон 1.5 км зайнаас усыг 110 мм бүхий хоолойгоор татаж үйлдвэрийн хойд хэсэгт байрлах 3000 м³ багтаамжтай (7 хоног) ил усан санд усыг хуримтлуулж үйлдвэрт ашиглана.

Хүснэгт 4. Уурхайн үерийн усны хэмжээ

Усны байршил	Эзлэхүүн, м ³
Баруун уурхай	430,581
Зүүн уурхай	1,972,459
Нийт уурхайд	2,403,040



Зураг 11. Ил уурхайн үерийн ус болон усан сан

Жилийн 1 сая тонны хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэрт дараах хэмжээний усыг ашиглана.

Үүнд:

- Үйлдвэрт шинээр нэмэх усны хэмжээ: 288 м³/өдөр (14-18 м³/цаг, 4-5 л/сек) 0.35 МПа
- 1 тонн түүхий нүүрс баяжуулахад ашиглах усны хэмжээ: < 0.1 м³/тн
- Үйлдвэр дотор нийт эргэлдэх усны хэмжээ: < 600 м³
- 1 цагт үйлдвэрт шинээр нэмэх усны хэмжээ: 14-18 м³/цаг
- 1 цагт үйлдвэрээс алдагдах усны алдагдал: $18 / 600 = 3\%$ баяжмалд чийг болж алдагдаж байгаа
- Үйлдвэрийн процесст нийт усны 97%-ийг эргүүлж ашиглана.

Баяжуулах үйлдвэрийн баяжмалын болон хаягдлын даралтат шүүлтүүрүүдийн шүүгдэж, хаягдлын өтгөрүүлэгчийн халианууд нийлээд эргэлтийн усыг бүрдүүлэх бөгөөд эргэлтийн усны зумф болон насосоор дамжин процессын хэрэгцээт газруудад түгээгдэнэ.

Баяжуулалтын бүтээгдэхүүнүүдтэй хам чийгшил байдлаар алдагдаж буй уснууд, мөн механикаар хаягдаж буй усыг гаднаас ирж буй цэвэр усаар сэлбэнэ.

2.3 НҮҮРС ХУУРАЙ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР FGX


Нүүрсийг хуурай аргаар баяжуулах FGX-12 болон FGX-24A маркийн үйлдвэрийг ашиглалтад оруулснаар жилд 2 сая.тн нүүрсийг боловсруулан, борлуулах боломж бүрдсэн.

Хуурай баяжуулах үйлдвэр нь дараах үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Түүхий нүүрс хүлээн авах бункер
- Ангилан бутлах хэсэг
- Үндсэн баяжуулах хэсэг
- Тээвэрлэх конвейрууд
- Удирдлагын байр

2.4 ТЕХНОЛОГИЙН ПРОЦЕСС

FGX хуурай баяжуулах үйлдвэрүүд нь 1 цагт 300 тонн, жилд 2 сая тонн гэжээлийн нүүрсийг баяжуулах хүчин чадалтай.




Зураг 12. Тоног төхөөрөмж холболтын схем

Хүснэгт 5. Материалын баланс

Бүтээгдэхүүн	Гарц, %	Гарц, тн	Үнслэг (%)	Чийг (%)	Илчлэг (ккал/кг)
Баяжмал	73,6	243	16,1	4,1	6301
Завсар	9,7	32	36,9	3,8	4572
Хаягдал	16,7	55	81,6	2,3	-
Тэжээл	100	330	29,1	3,8	5081

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Уурхайн уулын ажлын хүрээнд хийгдэж байгаа өрөмдлөг тэсэлгээ, олборлолт, тээвэрлэлт зэрэг үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй гол сөрөг нөлөөллийг доорх бүдүүвч зурагт үзүүлэв.



Зураг 13. Байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг харуулсан бүдүүвч зураг

3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Уурхайн байрлаж буй хэсэг нь бүс нутгийн онцлогийн хувьд говийн халуун, хуурай уур амьсгалтай, салхи шуурга ихтэй бүс бөгөөд ургамлын бүрхэвч тачир сийрэг, нимгэн давхаргатай хөрс тул тоосжилт ихээр үүсгээрэй онцлогтой.

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг 3 ангилав.

1. Тоосны тархалт
2. Нүүрс олборлолтоос үүсэх агаар бохирдуулагч хийн агууламж, тооцоолол
3. Дизель түлшнээс ялгарах хорт хийн агууламж, тооцоолол

Уурхайн бүсэд хөрс хуулалт, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хөрсний овоолго үүсгэх зэргээс үүдэн тоосжилтын асуудал үүснэ. Хуурай салхитай үед газрын гадаргаас тоос шороо агаарт дэгдэж салхины зонхилох чиглэлийн дагуу тархдаг. Тоосжилтын тархалтыг дараах хэсгүүдэд ангилан гүйцэтгэсэн болно.

1. Ил уурхайн олборлолтоос үүсэх тоосжилт

- a. TSP тоос
- b. PM10 тоос
- 2. Хөрсний овоолгоос үүсэх тоосжилт
 - a. TSP тоос
 - b. PM10 тоос
- 3. Технологийн замаас үүсэх тоосжилт
 - a. TSP тоос
 - b. PM10 тоос

Хүснэгт 6. Нүүрсний ил уурхайгаас үүсэх тоосонцрын хаягдал

Тоосжилтын эх үүсвэр	TSP тоосны ялгарлын фактор	PM10 тоосны ялгарлын фактор	Материал	Ялгарлын факторын үнэлгээ
Автосамосвалаар хаягдал буулгах	0.012 кг/тн	0.0043 кг/тн	Хаягдал чулуулаг	Е
Экскватороор хөрс ачих	0.025 кг/тн	0.012 кг/тн	Хаягдал чулуулаг	Е
Экскватороор нүүрс ачих	0.029 кг/тн	0.014 кг/тн	Нүүрс	С

Нөлөөллийн шинж чанар, эх үүсвэр, хэмжээ, эрчим: Хөрс хуулалт, хөрсний догол, мөргөцөг гаргах, мөн олборлолт хийх зэрэг ажлууд хийх явцад агаарт үүсэх их хэмжээний тоос, салхи, шуургаар дамжин тархалт явагдана. Говийн нөхцөлд салхины хурдны давтагдал их байдаг нь ордын үйл ажиллагааны нөлөөгөөр газрын хөрснөөс суларсан шороо хийсэж агаар бохирдуулах нь их байж болзошгүй юм.

Нөлөөлөлд өртөх зүйлс, тархалт, хамрах хүрээ: Уулын ажлын үед болон нүүрс тээвэрлэлтийн үед уурхайн орчимд их хэмжээний тоос, тоосонцор үүсэх бөгөөд энэ нь агаар орчинд төдийгүй уурхайн орчмын биологийн төрөл зүйл, уурхайн ажилчид болон ойр амьдрах хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.


Үргэлжлэх хугацаа: Агаар мандлын бохирдол нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд маш түргэн, үгүй бол маш удаан, эсвэл хүний бие махбодын тогтолцоог аажмаар удаан гэмтээх зэрэг янз бүрээр нөлөөлнө.

3.2 ХӨРСНИЙ ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Нарийн Сухайтын уурхай орчмын хөрс нь шим тэжээлийн түшингээр тааруу, ялмагийн агууламж бага 0.24-2.96%, элсэнцэр, элсэрхэг хөнгөн механик бүрэлдэхүүнтэй учир элэгдэл эвдрэлд орохдоо амархан хөрс юм.

Нөлөөллийн шинж чанар, эх үүсвэр, хэмжээ, эрчим: Уулын малталт, олборлолтын ажлын талбайг бэлтгэх, зам шинээр гаргах зэрэг хөрсний өнгөн хуулалт хийх, газар шорооны ажлыг эхлүүлэх үйл ажиллагаатай холбоотойгоор хөрс эвдэрч элэгдэлд орно. Уурхайд ашиглагдаж байгаа хүнд машин механизмын хөдөлгөөн, түрэлтээр орчны хөрсний үе давхаргууд гэмтэж, бороо хур ихтэй үед хөрсөн дээр хонхор үүсэж, хөрс эвдрэх магадлалтай.

Олборлолтын үеийн хөрсний эвдрэлээс шалтгаалан шороон шуурга болох нь олшрох, тоосжилт нэмэгдэх, цөлжилтийг эрчимжүүлэх шалтгаан болж болзошгүй.



Зураг 14. Уурхай орчмын хөрсний эвдрэлийн төлөв байдал

Нөлөөлөлд өртөх зүйлс, тархалт, хамрах хүрээ: Уурхайн үйл ажиллагаа тухайлбал тэсэлгээ, нүүрс тээвэр зэргээс болоод уурхай орчмын газар болон машин замын ойролцоо газруудад хөрсний элэгдэл үүсэж, ургамлын нөмрөгийн зүйлийн бүрдэл буурах, амьтад дайжих зэрэг нөлөөллүүд гарч болзошгүй.

Мөн хөрсөнд шатах тослох материалын асгаралтаас үүдээд хөрс өөрийгөө цэвэршүүлэх, сэргээх чадвар алдагдах эрсдэлтэй.

Үргэлжлэх хугацаа: Хөрсний элэгдэл эвдрэл нь удаан хугацаагаар үргэлжилнэ. Хөрсний өөрийгөө нөхөн төлжүүлэх чадвар харьцангуй удаан байдаг.

3.3 Усны найрлаг, чанарт үзүүлж болзошгүй нөлөөлөл

Усны эх үүсвэр болох худгийн ойр орчимд гүний усыг бохирдуулах үйл ажиллагаа явуулах, урсгалын эхэнд ус бохирдуулах үйл ажиллагаа явуулах (машин угаах, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал хаях), шатах тослох материал хөрсөнд асгарах зэрэг нь хөрсний сул ус болон хур тунадсаар дамжиж ундны ус цаашлаад гүний усыг бохирдуулна.

Нөлөөлөлд өртөх зүйлс, тархалт, хамрах хүрээ: Гүний худаг болон гадаргын усаар ундаалдаг хүн, мал амьтан, ургамал. Химийн хорт бодисууд усан сангийн ёроолд тунах үед эсвэл давхаргад нэвчих үед чулуулгийн хэсгүүдээр исэлдэн ангижрах, тунадасжих гэх мэт процесс явагддаг тул ус өөрөө бүрэн цэвэршиж чаддаггүй. Гүний усанд химийн хорт бодисууд нэвчимтгий чанартай хөрсөнд 10 км ба түүнээс цааш тархаж болно.

Үргэлжлэх хугацаа: Хөрсөнд нэвчсэн хорт бодис нь гүний усанд уусаж удаан хугацаагаар хадгалагдана.

3.4 УРГАМАЛ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГУЙ НӨЛӨӨЛӨЛ

Хөрс хуулалт болон тэсэлгээ, нүүрс тээврийн үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэлд орж ургамлын нөмрөг, тэжээллэг ашигт ургамлын зүйл буурах аажмаар алга болох эрсдэлтэй.

Нүүрс тээвэр болон тэсэлгээний үед их хэмжээгээр тоосонцор агаарт дэгдэх үед нарны цацрагийн шууд тусгалыг хаах түүний нөлөөгөөр ургамлын ургалт багасаж, анхдагч бүтээгдэхүүний бүтээмж буурах магадлалтай. Буурсан тохиолдолд идэш тэжээлийн гинжин хэлхээнд өөрчлөлт орох, амьтад идэш тэжээлээ даган нүүдэллэх тухайн нутгаас дайжих, хэрвээ идэш тэжээлээр дамжин хүнд металл болон химийн хорт нэгдлүүд амьтны биед орсон тохиолдолд тэдгээрийн гений санд өөрчлөлт орох гэх мэт эрсдэл гарч болзошгүй юм.

3.5 ХОГ ХАЯГДЛЫН НӨЛӨӨЛӨЛ

Хатуу хог хаягдал:

- Үйлдвэрлэлийн хог хаягдлын ихэнх хэсгийг хөрс хуулалтаас үүсэх сул шороон том хайрга, чулуун овоолго үүсгэж ихээхэн талбайг эзэлдэг.
- Харин ахуйн хог хаягдлын эх үүсвэр нь ажилчдын хотхон уурхайн захиргаа, зоогийн газар бөгөөд тэдгээрээс ихэвчлэн цаас, хуванцар сав, шил лаазны хаягдал гардаг.
- Засвар үйлчилгээний хэсгээс техникүүдийн сэлбэгийн хаягдал, шатах тослох материал асарч даавуу, шатах тослох материалын сав, түүний бөглөө жийрэг хөнгөн цагаан зэрэг хаягдал гарах бөгөөд эдгээрийн заримыг нь эргүүлэн ашиглаж байна. Гэвч эдгээрийг хурааж удаан хугацаанд хадгалах нь орчны болон агаарын бохирдлыг үүсгэх магадлалтай.

Шингэн хог хаягдал:

- Уурхайн шингэн хог хаягдлын гол хэсгийг ахуйн хэрэглээнээс гарах бохир ус, зоогийн газрын хоолны хаягдал бүрдүүлнэ.
- Хүний буруутай үйл ажиллагааны улмаас түлш түгээх болон, техникийн тосолгоо үйлчилгээ хийх явцад шатах тослох материал хөрсөн дээр хаягдаж бохирдол үүсгэж болно.

Хийн хаягдал:

- Уурхайн хийн хаягдал нь шатахуун буулгах, машин цэнэглэх үед болон орчны температурын нөлөөгөөр хүний буруутай үйл ажиллагаанаас болж автомашины шатахууны сав, агуулах савнаас хальж асарсан болон агуулах савны орчимд газрын гадарга дээр дуссан, асарсан түлшний ууршилтаас үүсэх хий зэрэг болно.
- Уурхай орчимд хүнд болон хөнгөн даацын автомашин, механизмуудын утаа нь мөн хийн хаягдлын гол эх үүсвэр болно.

БҮЛЭГ 4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зорилго:

Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгасан төлөвлөгөөт ажлуудыг авч хэрэгжүүлэн нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах аар боловсруулан, тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэх юм.

Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаа. Үүнд:


- Байгаль орчны хяналтыг сайжруулах, сөрөг нөлөөллийг цаг алдалгүй илрүүлж, арилгах арга хэмжээг богино хугацаанд зохион байгуулах;
- Байгаль орчны чиглэлээр орон нутагтай хамтран ажиллах хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, өргөжүүлэх;
- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах
- Мод үржүүлгийн талбайн ашиглалтыг сайжруулах төлөвлөгөөг гаргаж тарьц суулгацыг нөөцийг бүрдүүлэн Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарьж төрийн захиргааны төв байгууллагатай уялдаа холбоотой хамтран ажиллах.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1 АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ

5.1.1 Зам талбайг услах, тоосжилт дарах

Уурхайн сул хөрс, шороо салхинд хийсэхээс сэргийлэх, тоосны тархалтыг хязгаарлах зорилгоор үйл ажиллагаа явагдаж байгаа уурхай болон дотоод зам талбайн усалгааг тогтмол хийж гүйцэтгэн ажиллаж байна. 2023 оны 01 дугаар сараас эхлэн уурхайн хөрс тээвэр, нүүрс олборлолт, борлуулалт хэвийн ажиллаж эхэлсэн. Зам талбайн тоосжилт дарах зорилгоор нийт 10 дугаар сарын байдлаар 142,212 м³ усыг эргүүлэн ашигласан байна. Хамгийн их ус зарцуулалтай үе 06 сар байсан бөгөөд цаг агаар халуун, салхи шуурга их байсантай холбоотойгоор усалгааг нэмэгдүүлж байсан. 10 дугаар сарын хувьд хүйтэрч, салхи шуурга багатай байсан учир усалгааг багасгаж ажилласан.



Зураг 15. Зам талбайн тоосжилт дарахад ашигласан усны хэмжээ, сараар

Хүснэгт 7. Зам усалгааны машины усны хэмжээ болон рейсийн тоо

Он/сар	Техник	Payload Tonnes	Рейс
Jan-2023	Total	3,809.0	157.0
Feb-2023	Total	2,337.0	391.0
Mar-2023	Total	8,756.0	570.0
Apr-2023	Total	17,944.0	600.0
May-2023	Total	13,678.0	550.0
Jun-2023	Total	22,027.0	949.0
Jul-2023	Total	18,616.0	813.0
Aug-2023	Total	18,826.0	894.0
Sep-2023	Total	18,074.0	498.0
Oct-2023	Total	18,145.0	647.0
Grand Total		142,212.0	6,067.0



Зураг 16. Уурхайн карьер болон зам талбайн тоосжилт дарах усалгаа

Технологийн замын усалгааг сайжруулах зорилгоор 1259 м уртай хөрс тээврийн замд 25 м радиуст усалгаа хийх хүчин чадалтай бороожуулагч системийг дулааны улиралд ашиглаж байна.



Зураг 17. Зам усалгааны бороожуулагч систем

5.1.2 Зам талбайн тэмдэг тэмдэглэлээ нэмэгдүүлэх, хурдны хязгаарыг мөрдүүлэх


Уурхайн дотоод тээврийн зам дээр МУ-н замын хөдөлгөөний дүрэм болон уурхайн замын хөдөлгөөний журмыг дагаж мөрдөн хурдны хязгаар тогтоон нийт 40 ширхэг тэмдэг байрлуулан ажилласан.



Зураг 18. Уурхайн бүсэд тээврийн хэрэгсэл жолоодох, түр үнэмлэх ашиглах журам


Хүснэгт 8. Уурхайн орчинд мөрдөж байгаа хурдны хязгаар

Д/д	Замын нэр	Хурд /км, цаг/	
1	Овоолгын зам	40	
2	Гадаргуугийн зам	60	
3	Траншейн зам	40	
4	Мөргөцгийн зам	Нүүрсний зам	30
		Хөрсний зам	40
5	Хатуу хучилттай зам	Хотхон - ЗҮТ	60
		Гаалийн хяналтын талбай – Шивээ хүрэн боомт	80



Зураг 19. Замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулж байгаа байдал

Мөн 2023 оноос үйлчилгээний машинуудын хурдны хязгаарыг хянах зорилгоор “Гайхам” ХХК-р GPS суурилуулан хяналт тавьж ажиллаж байна.



Зураг 20. Гайхам системийн хяналтын зураг

Гайхам ХХК-ийн ИТА-д 2023 оны 4-р сарын 4-өөс 7-ны хооронд жагсаалт / дахь тээврийн хэрэгслүүдэд GPS төхөөрөмж, түлш хэмжигч суурилуулж хүлээлцсэн тайлан

4/7/2023

№	Утсын дугаар	Паркийн дугаар	Зориулалт	GPS төхөрөмж / FMC125	Түлш хэмжигч RCS-ESH4 770мм-тэй	Түлш хэмжигч RCS-ES14 1000мм-тэй	Түлш хэмжигч RCS-1/SH4 1200 мм-тэй	Түлш хэмжигчтэй эсэх
1	04-79 УББ	LANE: 79 N609	Суудал					
2	05-79 УБЗ	LANE: 79 N608	Суудал					
3	06-56 УНӨ	LANE: 76 N613	Суудал					
4	11-38 УБГ	Terra xl 006	Суудал					
5	11-63 УНӨ	LANE: 76	Суудал					
6	17-66 УНР	North benz №114-01	Тосолгоо, үйлчилгээ		1			түлшний мэдэгчтэй
7	23-89 ӨМӨ	HYUNDAI aero city	Хүн тээвэр					
8	32-17ӨМЭ	Sinotr ack howo 290 №114-01	Тосолгоо, үйлчилгээ		1			түлшний мэдэгчтэй
9	34-23ӨМЭ	Sinotr ack howo 290 №117	Авто чирэгч		1			түлшний мэдэгчтэй
10	35-12ӨМЭ	Sinotr ack howo 290 №120	Бохир соруулалт машин		1			түлшний мэдэгчтэй
11	49-30 УНХ	Nissan: detiel №110	Түлш тээвэр		1			түлшний мэдэгчтэй
12	50-29 УНА	LANE: 79 №17	Суудал					
13	53-81 УНД	Zoomlion	Кран		1			түлшний мэдэгчтэй
14	54-01 ӨМЭ	SINO TRUCK / Тусгай тээвэр / 371	Галын машин					
15	55-00 УНЗ	LANE: 79 N606	Хагас авчмаа					
16	60-63 ӨМӨ	LANE: 78 /103/	Эмнэлэг		1			түлшний мэдэгчтэй
17	63-68 ӨМӨ	Nissan: detiel №112	Түлш тээвэр		1			түлшний мэдэгчтэй
18	66-27 УБЧ	LANE: 78 Харуул	Суудал		1			түлшний мэдэгчтэй
19	68-46УНМ	Sinotr ack howo 290 №118	Өрөөний усны машин		1			түлшний мэдэгчтэй
20	71-77 УББ	LANE: 76 N604	Суудал					
21	76-21 УАС	LANE: 76 №15	Хагас авчмаа					
22	78-74 УНМ	LANE: 76	Суудал					
23	80-53 УНР	LANE: 79 №16	Хагас авчмаа					
24	81-40 УАС	LANE: 79 №12	Хагас авчмаа					
25	82-10 УАС	LANE: 79 №10	Хагас авчмаа					
26	82-30 УАС	LANE: 79 N605	Хагас авчмаа					
27	89-47 ЕУН	nissan diesel	Түлш тээвэр		1			түлшний мэдэгчтэй
28	98-94 УНБ	LANE: 78 №11	Суудал		1			түлшний мэдэгчтэй
29	62-62 ӨМӨ	LIEBHERR LTM-1100	Явгч			1		түлшний мэдэгчтэй
30		LIEBHERR LTM-1100	Кран				1	түлшний мэдэгчтэй
31	86-21 УАМ	HYUNDAIHD330 №116-02	Кран		1			түлшний мэдэгчтэй
32	09-24 УР	XCS4131K	Чингэлэг ашигч		1			түлшний мэдэгчтэй
33	35-64 УАС	LANE: 78 N601	Суудал		1			түлшний мэдэгчтэй
34	54-71 ӨМА	Sinotr ack howo 371 №119	Хөг хаягдал зөөвөрлөх машин		1			түлшний мэдэгчтэй
35	73-60 УАС	LANE: 78 N602	Суудал		1			түлшний мэдэгчтэй
36	77-26 ӨМӨ	HYUNDAIHD250 №116-01	Кран		1			түлшний мэдэгчтэй
37	81-70 УАС	LANE: 78 N603	Суудал		1			түлшний мэдэгчтэй
Нийт гоо				37	19	1	1	


Ажил хүлээсэн

Гайхам ХХК-ийн ИТА-д
 Хувьцааны менежер Д.Батбаяр
 Төсвийч Г.Анхбаяр
 Төсвийч Т.Уугаабаатар
 Д.эрх суурилуулалттай холбоотой дэлгэрэнгүй ахуйг хансарсан.

МАК Нарийн сухайт уурхай
 Ерөнхий захирал Е.Содойвоо
 Нэгдсэн б.д.г.ч Г.Энхтөгсөлдөр
 Ашиглалт-аг инженер Р.Уугаабаяр

Зураг 21. Гайхам системийг хүлээн авсан акт

шалгалтыг долоо хоногт 2 удаа тогтмол хийж, зөрчил гарсан үед хариуцсан хэсэг нэгжид албан шаардлага хүргүүлэн арга хэмжээ авч ажилласан.



Зураг 23. Уурхайн ШТС, тосны агуулах

Хүснэгт 9. Ажлын байрны үзлэг шалгалт зөрчил

№	Хэсэг нэгжүүд	Гарсан зөрчлийн тоо	Зөрчлийг арилгасан тоо	Сайжруулалт хийж байгаа ажил
1	Засвар үйлчилгээний хэсэг	210	210	1. Зориулалтын газар үйлчилгээ хийлгэх 2. Зогсож байгаа техникүүдээс тос гоожихгүй байлгах арга хэмжээ авах 3. Засварын мастер, инженерүүд хяналтыг сайжруулах, бүртгэх
2	Уулын хэсэг	7	7	Зогсож байгаа техникүүдээс тос гоожихгүй байлгах арга хэмжээ авах.
3	Аж ахуйн хэсэг	14	14	-
4	Санхүүгийн хэсэг	3	3	Шинэ тос, масло-ын хадгалалт, тээвэрлэлтэд хяналт тавих
5	Баяжуулах үйлдвэрийн хэсэг	3	3	-
6	Цахилгааны хэсэг	2	2	-
Бүгд		239	239	-

МАК
МОНГОЛЫН АЛТ ХХК

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хэсэг

Эхлэх хугацаа: 2023/10/24	Дуусах хугацаа: 2023/10/25	Түргэлжлэх хоног: 1 хоног
Албан даалгавар өгсөн: ХАБЗА-ын инженер Т.Амаргүвшин	Ахуйн байрны үзлэг хийсэн: БО-ны мэргэжилтэн Б.Тэнгис	
Гарын үсэг: <i>T. Amargushin</i>	Гарын үсэг: <i>B. Tengis</i>	
Танилцсан: Уурхайн дарга А.Цолмонбалар	Гарын үсэг:	
Танилцсан: Орлогч дарга П.Зоригтоо	Гарын үсэг:	
Танилцсан: Уурхайн дарга А.Цолмонбалар	Гарын үсэг:	
Албан даалгавар лутган авч арилтаг албан тушаалтан, Аллах механик: С.Өлзийбат		
Гарын үсэг: <i>S. Oltzibat</i>		

Үзлэг шалгалт хийх хуваарь

Албан шаардлага хүргүүлсэн байдал

Засвар үйлчилгээний хэсгийн үл тохирол арилгасан тайлан

Байршил: ЗҮТ угсралтын талбай

1. Хаягдал шоошиг болон бусад хог хаягдлыг ангилан ялгаж хогийн цэгт хаях
2. Тостой хөрсийг хусаж авах, хуссан талбайд шороо асгаж тэгшлэх
3. Угсралтын талбайн эмх цэгцгийг хангах



Зураг 24. Үзлэг шалгалт хийх төлөвлөгөө болон албан даалгавар өгсөн байдал хариу ирүүлсэн талаар

5.2 ХӨРСНИЙ ЧАНАРТ НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

5.2.1 Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох, бүртгэл хөтлөх



2023 онд 12225А ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд уурхайн олборлолтын үйл ажиллагааг 2023 оны 01 дугаар сараас эхлэн явуулсан бөгөөд карьерын тэлэлт, хөрсний овоолго, зам талбай, олборлолтын цооногийн зориулалтаар нийт 33,28 га талбай хөндөгдсөн байна.


Хүснэгт 10. 2023 оны хөндөгдсөн газрын хэмжээ га, 11 сар

№	Хөндөгдсөн газрын хэмжээ /га/	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	Нийт
1	Зам талбай засах	7,1		0,5			0,2		0,1		4		11,9
2	Карьер тэлэх	0,1	0,9					0,7	0,1		14,4		16
3	Хөрсний овоолго		0,2	0,7	0,6	0,4	0,5	0,8	0,3	0,8			4
4	Олборлолтын цооног			0,3		1,08							1,38
Бүгд		7,2	1,1	1,5	0,6	1,48	0,7	1,5	0,5	0,8	18,4	0	33,28

Дээрх графикаас харахад 10 дугаар сард 18.4 га талбай буюу хамгийн их талбай хөндсөн бол 08 дугаар сард хамгийн бага буюу 0.5 га талбайг хөндсөн байна.

Уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулах зорилгоор 7, хөрсний овоолгын зориулалтаар 8, зам талбай засах зориулалтаар 5 нийт 20 газар хөндөх зөвшөөрөл авч ажилласан байна.





Зураг 25. Газар хөндөх зөвшөөрөл авсан байдал


5.2.2 Үржил шимт хөрсийг хуулж хэлбэржүүлэх

Уурхайн хэмжээнд нийт 315,730.2 м³ шимт хөрсийг хуулж 6 байршилд стандартын дагуу овоолго үүсгэн хэлбэржүүлэн хадгалж байна. Үүнээс 118,973 м³ эзлэхүүнтэй шимт хөрсний № 4 овоолгын 0,74 га талбайд төлөвлөгөө гаргаж өлөнгө, царгас, хүцэнгэ зэрэг олон наст өвслөг ургамал тарьж, шар хуайс, жигд зэрэг модны 130 ширхэг суулгацыг шилжүүлэн тарилт хийж, усалгаа арчилгааг тогтмол хийсэн.

Хүснэгт 11. 2023 онд хуулж хэлбэржүүлсэн шимт хөрсний овоолгын дугаар, хэмжээ

№	Овоолгын дугаар	Байршил	Хэмжээ, м ³	Үүсгэсэн он	Нөхөн сэргээлт хийсэн эсэх
1	№ 4	Хөрсний 5-р овоолгын урд, шинэ карьерын ард	16,884	2023	Хэлбэржүүлж, 2023 онд олон наст ургамал, мод тарьсан.

2023 онд нийт 8 га талбайд шинээр тэлэлт хийж, 7202 м³ шимт хөрсийг хуулж, шимт хөрсний 4 дүгээр овоолгод нэмэлтээр стандартын дагуу овоолго үүсгэн хадгалж байна. 2023 онд шинээр шимт хөрсний талбай үүсгээгүй, шимт хөрсний 4-р овоолгод нэмэлтээр 16,884 м³ шимт хөрсийг буулгасан.



Зураг 26. Шимт хөрсний овоолгын байршил

5.2.3 Шимт хөрсний чанар болон хөрсний мэдээллийг агуулсан самбар хийж байршуулах


Стандартын дагуу хэлбэржүүлсэн шимт хөрсний 4-р овоолго дээр мэдээллийн самбар байршуулсан. Мэдээллийн самбарт шимт хөрсний овоолгын эзлэхүүн болон га талбайн хэмжээ, биологийн нөхөн сэргээлт хийсэн тоо баримтыг оруулсан.



Зураг 27. Шимт хөрсний №4 овоолгод байршуулсан самбар

5.2.4 Тогтсон маршрутын дагуу хөдөлгөөнд оролцох

Нүүрс тээвэрлэлтийг 56 км хатуу хучилттай замаар, хөрс тээвэрлэлт болон уурхайн дотор явж байгаа бусад техникуудийг арчилгаа усалгаатай замаар, ажилчдын байр болон засвар үйлчилгээний төв хооронд зорчихдоо 3 км хатуу хучилттай замаар хөдөлгөөнд оролцдог



Зураг 28. Уурхайд ашиглаж байгаа зам талбайн ерөнхий зураг

5.2.5 Тосолгоо үйлчилгээг зориулалтын талбайд хийх

Дунд оврын болон үйлчилгээний жижиг машинуудын тосолгоо үйлчилгээг засвар үйлчилгээний төвд 483.7 м² хатуу хучилттай зориулалтын талбайд, 130 тн болон 220 тн белаз автосамосвалуудын тосолгоо үйлчилгээг 172 м² бетондсон зориулалтын талбайд хийж байна.



Белазын үйлчилгээ хийх талбай




Дунд оврын болон жижиг машинуудын
үйлчилгээ хийх талбай

Зураг 29. Бетондсон засварын талбай болон засварын зориулалтын талбай



Зураг 30. ЗҮТ-ийн техник засварын талбайн зураг

Стандартын шаардлагын дагуу зассан хатуу хучилттай талбайд хаягдал тос маслыг 25 м3, гидрийн шингэнийг 15 м3-ийн багтаамжтай саванд хадгалж, хаягдал тос боловсруулах “Монпити - Ойл” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд тайлант онд 84 тн тос нийлүүлсэн.



Зураг 31. Хаягдал тос хадгалах сав, технологийн зураг

5.2.6 Хөрс хамгаалал, бохирдлоос сэргийлэх, арилгах талаар нийт ажилчдад сургалт явуулах

Хөрс хамгаалах, бохирдлоос сэргийлэх талаар уурхайн нийт ажилчдад заавар зааварчилгаа өгч ажилласан. Мөн уурхайн 2023 онд нийт ажилчдад 2 сургалт орсон бүртгэлийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 12. Хөрсний бохирдлын сургалт

№	Сэдэв	Сургалтад хамрагдсан хүний тоо, сараар											Нийт
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
1	Хөрсний бохирдол, түүнийг арилгах			352				342			300		994

2	Санамсаргүй олдворын үед ажиллах журмыг хэрэгжүүлэх тухай сургалт	200		353		215		341		210		1319	
3	Хог хаягдлын менежмент	98	300			200	112		102	245	280	1337	
4	Усны зохистой ашиглалтын талаар						227			298	254	899	
5	Хүлэмжийн хийн гол эх үүсвэр, бууруулах боломжууд						250	364	315	145		1074	
6	Шинэ ажилчдад заах байгаль орчны анхан шатны сургалт	86	90	93	72	60	41	38	37	62	48	650	
											23		
Нийт		384	390	798	72	475	630	1085	454	960	882	143	6296



Зураг 32. Сургалт орж буй байдал

The image contains three tables, each representing an environmental management plan for a specific section of the mine. Each table has a header with the section name and a date. Below the header is a grid of icons representing different types of equipment or activities. The main body of each table is a list of items with columns for '№', 'Төрөл', 'Төр', 'Хэрэглээ', 'Ашигласан өдөр', and 'Төлөвлөгөөний өдөр'. The tables are filled with handwritten entries and signatures.

Зураг 33. Сургалтын баталгаажуулалт гарын үсэг

5.2.7 Хөрс саармагжуулах талбай хийх

Газрын гадарга, хэвлийн элэгдэх, доройтох нөлөөлөлд өртөхөөс хамгаалан уурхайн уулын хэсгийн 5-р секторт байрлах засварын талбайд шинээр 8:20 м2 хэмжээтэй талбайг 160 м2 гео мембран ашиглан тостой хөрс саармагжуулах талбайг шинээр хийсэн (х а в с р д л т 3 б



Зураг 34. Геомембран

БАТЛАВ УУРХАЙН ДАРГА А.ЦОЛМОНБАЯР

ХӨРС СААРМАГЖУУЛАХ ТАЛБАЙ БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ундлах: Уурхайн Байгаль орны зөвлөхөөс үзүүлж, 2023 оны Байгаль орны менежментийн төлөвлөгөө болон Хөрс хамгаал, ашиглас, түгээгдсэн, хадгалж, тэжээх, устгах журмыг хэрэглэж байгаа.

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орныг урт хугацаагаар хамгаалах, хөрс болон гүний усны бодирлоос урьдчилан сэргийлэх.


№	Хөрс саармагжуулах талбай	Хэмжээ (м²)	Хөрс хадгалж хэмжээ	Тайлбар
1	Уул 1-ийн хөрс саармагжуулах талбай	58450	1508 м³	ЗУТ болон УХ-ийн тосгой тэрэг хадгалж талбайн нэрсийг ариутгаж хөрсөд нэвчлүүлж бодирлоос саармагжуулах хийж талбай
2	ЗУТ-ийн тосгой тэрэг хадгалж талбай	39639	608 м³	ЗУТ-ийн үйлчилгээний явцад бодирлоос хөрсийг хадгална
3	УХ зуучин төсвийн талбайн тосгой тэрэг хадгалж талбай	30430	300 м³	УХ-г өндөр тосгонд ашиглас үйлчилгээний явцад бодирлоос хөрсийг хадгална
Нийт		128519 м²		

Талбайн байгууламж хэмжээ (м²)

№	Материалын нэр	Хэмжээ	Тайлбар
1	Шивнэг	65 м³	Тосгоос хамгаалах шивнэг зориулалт
2	Хайрца (хөрс ариутгагч)	228 м³	Уурхайн сумын ЗДТ-аас хөрсөд нэвчлүүлж уурхайн төсвийн хамгаалах буюу
3	Хайрца (хөрс ариутгагч)	80 м³	Дотоод нэмж бодирлоос
4	Хамгаалах буюу бууцагч	-	Дотоод нэмж бодирлоос

Талбайн тус бүрийн байршил болон бусад мэдээллийг харуулах нэмэлт зураг хавсаргана.

Хөрсний
Орлогч дарга: *Н.Зориг* Ш.Зориг
ХАБСЭМХ-ийн дарга: *В.В* Э.Валгун
Болговруулагч: *С.Ламсцал* Э.Савсав
БЭ-ийн дарга: *С.Түвшин* С.Түвшин
БЭ-ийн дарга: *С.Түвшин* С.Түвшин



Зураг 35. Хөрс саармагжуулах талбайн төлөвлөгөө

5.3 Усны чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

5.3.1 Уурхайн хугдийн тоолууруудын заалтыг авч акт үйлдүүлэх

Уурхайн ажилчдын унд ахуйн хэрэглээний ус болон нүүрс баяжуулах үйлдвэрт ашиглаж байгаа үйлдвэрийн усны хэрэглээг хянах зорилгоор баталгаажсан тоолууруудыг ашиглаж байна.

Унд ахуйн зориулалтаар ашигладаг 4 ш тоолуур, нүүрс угаах үйлдвэрийн зориулалттай 1 ш, шүүрлийн усанд 1ш тоолуур суурилуулан, нийт 6 ш тоолуурын заалтыг сар бүрийн 25-нд авч акт үйлдэн Гурвантэс сумын байгаль хамгаалагчаар баталгаажуулан хэрэглэсэн усны төлбөрийг төлдөг (*Усны тоол ухуарвьснр аалкүтс 2 ы төлбөрийн бйрмтууд хав*)

2023 онд 7 сард унд ахуйн 5 ш, баяжуулах үйлдвэрийн 1 ш тоолуурын хугацаа дуусан тул шинээр сольж, “Межур мойл” ХХК –р лацдуулан холболт хийж стандарт хэмжилзүйн газраар баталгаажуулсан тоолуур суурилуулсан.

Хүснэгт 13. Уурхайд ашиглаж байгаа баталгаажсан тоолуурын мэдээлэл

№	Тоолуурын байршил	Тоолуурын дугаар	Баталгаажуулалт хийсэн хугацаа	Хэрэглээний зориулалт	Тоолуурын диаметр, мм
1	Дунд тосгон	2303099604	2023.07.01	Унд ахуй	100
2	Гал тогоо	2206099616	2023.07.01		25
3	Угаалгын байр	2303099327	2023.07.01		25
4	НБҮ ахуй	2206099632	2023.07.01		25
5	НБҮ процесс	2303099579	2023.07.01	Үйлдвэр	100
6	Шүүрлийн ус	2110004987	2023.07.01	Шүүрэл	150

5.3.2 Унд ахуйн худгийн орчинд цэвэрлэгээ хийх

Уурхайн ажилчдын ундны усны худгийн эрүүл ахуйн бүс нь уурхайн харуул хамгаалалтын албаны байнгын хяналтад байдаг ба эрүүл ахуйн бүсийн хог хаягдлын цэвэрлэгээг “Уурхайн орчны цэвэрлэгээ хийх хуваарь”-ийн дагуу сард нэг удаа цэвэрлэгээ хийдэг бөгөөд нийт 10 удаа цэвэрлэгээ хийж 600 кг ахуйн хуурай хог хаягдлыг түүж, уурхайн хог хаягдал түр хадгалах талбайд ангилан ялгаж “Шугшаа Уул” ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу устгуулсан.

Сар	Цэвэрлэгээний өдөр	Хог хаягдлын хэмжээ (кг)	Хог хаягдлын ангилал	Хог хаягдлыг устгуулсан байр
Январь	05	120	Хуурай хог хаягдал	“Шугшаа Уул” ОНӨААТҮГ
Февраль	08	110	Хуурай хог хаягдал	“Шугшаа Уул” ОНӨААТҮГ
Март	10	130	Хуурай хог хаягдал	“Шугшаа Уул” ОНӨААТҮГ
Апрель	12	140	Хуурай хог хаягдал	“Шугшаа Уул” ОНӨААТҮГ
Май	15	150	Хуурай хог хаягдал	“Шугшаа Уул” ОНӨААТҮГ
Июнь	18	160	Хуурай хог хаягдал	“Шугшаа Уул” ОНӨААТҮГ
Июль	20	170	Хуурай хог хаягдал	“Шугшаа Уул” ОНӨААТҮГ
Август	22	180	Хуурай хог хаягдал	“Шугшаа Уул” ОНӨААТҮГ
Сентябрь	25	190	Хуурай хог хаягдал	“Шугшаа Уул” ОНӨААТҮГ
Октябрь	28	200	Хуурай хог хаягдал	“Шугшаа Уул” ОНӨААТҮГ
Ноябрь	30	210	Хуурай хог хаягдал	“Шугшаа Уул” ОНӨААТҮГ
Догоо		1800	Хуурай хог хаягдал	“Шугшаа Уул” ОНӨААТҮГ




Зураг 36. Орчны цэвэрлэгээ хийх батлагдсан төлөвлөгөө




Зураг 37. Орчны цэвэрлэгээ хийх байгаа байдал

5.3.3 Усны нөөцийн савны ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх



Өмнөговь аймгийн “Хүслэн хийморь” ХХК-иар ундны усны нөөцийн савнуудад улирал бүр технологийн дагуу механик цэвэрлэгээ, стандартын дагуу ариутгал хийлгэж гүйцэтгэл дээр акт үйлдэж хүлээн авсан (*Хүслэн Хийморь ХХК хянагч ажилтан*) *т т 2 8 х г э р*



Зураг 38. Ариутгал халдваргүйтгэл хийлгэх гэрээ байгуулсан байдал



Зураг 39. Усны нөөцийн саванд ариутгал хийлгэсэн байдал



Зураг 40. Усны нөөцийн саванд ариутгал хийсэн акт

5.3.4 Булаг шандын орчимд цэвэрлэгээ хийх

X/09 -ны өдөр Нарийн сухайтын уурхайгаас хойшоо 7 км-ийн зайд байрлах “Ногоон чулуу”-ны булаг болон Сухантын булаг, хөв цөөрмийн ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулсан. Уг ажилд Нарийн сухайтын уурхайн бүх хэсэг нэгжүүд хамтран ажилласан.

Үүнд: Төлөвлөлт, ХАБЭАБО, Лаборатори, Захиргаа, санхүү, Аж ахуй, ЗҮХ, Захиргаа, Цахилгаан, Уул зэрэг 9 хэсэг нэгжүүдийн инженер техникийн ажилчид оролцсон.



Зураг 41. Булаг шандын ойр орчмыг цэвэрлэсэн зураг

5.3.5 Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах

Уурхайд ажиллаж байгаа нийт 6 ээлжийн 1100 орчим ажилчдад “Усны хэрэглээ, нөөц” – ийн талаарх сургалтыг 3 удаа зохион байгуулан ажиллаа.



Зураг 42. Усны сургалт

Мөн Монголын Алт ХХК-ийн “Усны менежментийн журам”-ын танилцуулга, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар компанийн Байгаль орчин, тогтвортой хөгжлийн газраас сургалт явуулсан. Нийт 480 ИТА болон ажилчид хамрагдсан.

The image displays three tables, each representing a different group of employees who completed the water management training. Each table includes columns for employee ID, name, position, and a checkmark indicating completion. The tables are signed by the training organizers.

Зураг 43. Усны сургалт орсон ажилчдын баталгаажуулах гарын үсэг зурсан байдал

Усны зүй зохистой ашиглалт, хэмнэлтийн талаар оролцоог нэмэгдүүлэх, мэдээлэл өгөх зорилгоор ажилчдын амрах байр болон нийтийн 00, душ, зоогийн газрын угаалтуур, толь зэрэгт стикерүүд хэвлэж байршуулсан.



Зураг 44. Сургалт орж буй болон стикер байрлуулж буй байдал



5.3.8 Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх

Жил бүрийн III/22 –н өдрийг “Дэлхийн усны өдөр” хэмээн уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлдэг.

“Хүрэн толгой коал майнинг” –тай хамтран тус өдрийг Гурвантэс сумын ЕБС-ийн I-V ангийн сурагчдын дунд “Ус ба амьдрал” сэдэвт гар зургийн уралдаан, VI-XII ангийн сурагчдын дунд “Хаягдал батерэй” цуглуулах савны загвар гаргах уралдаан зарлаж, шагналт байранд шалгарсан сурагчид болон анги хамт олноо идэвхтэй оролцуулсан багш нарыг тус тус шагнаж урамшуулав.



Зураг 47. Шагналт байр эзэлсэн сурагчид



Зураг 48. Тэмцээн зохион байгуулал удирдамж


Анги хамт олноороо идэвхтэй оролцсон ахлах ангийн хоёр бүлгийн шагнал, урамшуулалд нэмэлтээр “Уурхайтай танилцах аялал” зохион байгуулсан бөгөөд энэ нь сурагчдад маш өндөр сэтгэгдэл төрүүлж, сурагчдад мэргэжлээ сонгоход чухал түлхэц болсон гэдгийг дурдаж байлаа.

5.3.9 Тайлант онд ашигласан усны хэмжээ

2023 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар унд ахуйд 35,616 м³, шүүрлийн ус болон үерийн уснаас тоосжилт дарахад 142,212 м³, ногоон байгууламж нөхөн сэргээлтэд 23,164 м³, баяжуулах үйлдвэрт 38,765 м³ нийт 239,757 м³ ус ашигласан (*х а в с р д л т 3 5*)

Хүснэгт 14. Усны хэрэглээ, зориулалт эхний 10 сарын байдлаар

д/д	Зориулалт	Эх үүсвэр	2023 онд ашигласан хэмжээ м ³	Тайлбар
1	Унд, ахуй	Гүний худаг	35,616	Баталгаат тоолуурын заалтаар
2	Тоосжилт дарах	Үерийн болон шүүрлийн ус	142,212	Баталгаат тоолуурын заалтаар
3	Ногоон байгууламж, нөхөн сэргээлт	Үерийн ус	23,164	Баталгаат тоолуурын заалтаар
4	Баяжуулах үйлдвэр		38,765	Баталгаат тоолуурын заалтаар
Нийт			239,757	



Зураг 49. Нийт ашигласан усны хэмжээ, тн

Дээрх графикаас харахад зам талбайн тоосжилт дарах зориулалтаар 6 дугаар сард 22,027 м3, 08 дугаар сард 18,826 м3 ус ашигласан нь зарим сард шороон шуурга их шуурах, зарим сард их халалтаас шалтгаалан зам талбайн усалгаа бусад саруудаас илүү хийгдсэн байна. Баяжуулах үйлдвэрийн хувьд тухайн жилд үйлдвэрийн үйл ажиллагаа хэвийн үйл ажиллагаатай байгаа ба дүгнэлтэд заасан хэмжээнээс ус ашиглалт 74.0% харьцангуй бага зарцуулсан байна (х а я г д а л у с н ы д ү г н э л т х џ в с р а л т 3 4

2016-2023 оны хооронд ашигласан усны хэмжээ

Сүүлийн 7 жилийн уурхайн ус ашигласан байдлыг тухайн жилийн ус ашиглах дүгнэлтийн дүнтэй харьцуулж харахад ус ашиглах дүгнэлтээр нийт 4,711,377. м3 усыг ашиглуулахаар зөвшөөрөл олгосон бол 1,804,622.0 м3 усыг ашигласан байна. Нийт 7 жилийн турш 2,850,570.43 м3 буюу 38.5 %-ийг дүгнэлтэд заасан хэмжээнээс бага буюу хэмнэж ашигласан (х а в с р џ л т 4 3

Хүснэгт 15. Тухайн жилийн ус ашиглалтыг ус ашиглах дүгнэлттэй харьцуулсан байдал, 2016-2023 он

Он	Дүгнэлт	Ашигласан	Зөрүү	Ус ашиглалтын хувь, %
2016	300,971.90	84,541.00	216,430.90	28.1
2017	280,885.60	128,652.00	152,233.60	45.8
2018	513,029.20	305,387.00	207,642.20	59.5
2019	578,366.40	274,541.75	303,824.65	47.5
2020	634,681.15	317,773.53	316,907.62	50.1
2021	806,878.46	303,637.50	503,240.96	37.6
2022	767,789.00	128,844.50	638,944.50	16.8
2023	751,103	239,757	511,346	32
Нийт	4,633,704.71	1,783,134.28	2,850,570.43	38.4



Зураг 50. Ус ашиглалт 2016-2023 оны харьцуулалт

Хүснэгт 16. Усны бичиг баримтын бүрдэл

№	Бичиг баримтын нэр	Зөвшөөрөл авах газар	Гарсан он	Дуусах хугацаа	Дугаар	Зөвшөөрөгдөх хэмжээ /мЗ/
1	Тухайн жилийн ус ашиглах дүгнэлт	Усны газар	2023.04.23	2023.12.31	A05/797	
2	Тухайн жилийн ус ашиглах зөвшөөрөл	Алтай өвөр говийн сав газрын захиргаа	2023.08.01	2023.12.31	A/28	689,100 Үйлдвэрт
3	Тухайн жилийн ус ашиглах гэрээ	Алтай өвөр говийн сав газрын захиргаа	2023.08.01	2023.12.31	803-2623	61,282.8 Унд ахуйд
4	Хаягдал усны дүгнэлт	Усны газар	2022.12.28	2023.12.28	06/158	
5	Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл	Алтай өвөр говийн сав газрын захиргаа	2022.12.13	2023.12.13	006	
6	Хаягдал усыг байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй байгуулах ус бохирдуулсны төлбөрийн гэрээ	Алтай өвөр говийн сав газрын захиргаа	2022.12.28	2023.12.28	399-1923	38309

5.4 АМЬТАН, УРГАМЛЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭХ АЖЛУУД

5.4.1 Амьтны судалгаа хийж гүйцэтгэх

Амьтны мониторингийг 20 км радиуст Баруун Сухант, Зүүн Сухант, Нүдэн булаг, Хайлаастын ам, “Өсөх Зоос” ХХК-ийн нүүрс тээврийн зам гэсэн цэгүүдээр явж гүйцэтгэсэн. Тус газруудаар явахад нийт 37 хар сүүлт, 2 сар шувуу, 1 тас, тус тус бүртгэгдсэн болно. Нийт 56 бодгаль ажиглагдсан байна. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нийт газар нутагт хэт хуурайшилт ихтэй байгаа учир өвс тэжээлийн дутмаг байдал үүсэж, зэрлэг ан амьтан бэлчээр дагаж шилжин тоо толгой цөөрөх тохиолдол их байна (*А м ь т н ы м о н и т о р и н г с у д а л г а а н ы*). *а ж л ы н т а*


Уурхайн нөлөөллийн бүсийн амьтны судалгааг хийснээр шаардлагатай биотехникийн арга хэмжээ авах төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлж ажилласан.

Хүснэгт 17. Судалгааны үед тааралдсан амьтны байршил, тоо толгой

№	Монгол нэр	Газрын нэр	Газар зүйн байршил	Тоо хэмжээ	Нийт
1	Хондон ангир	Баруун сухант	47Т0688405 4761119	6	6
5	Хар сүүлт зээр	Баруун сухант орох замд	47Т0688354 4761252	2	31
6		Морин зам орчим	47Т0679333 4755496	8	
7		Нүдэн булаг орчим	47Т0670001 4757584	3	
8		Өсөх зоосын баруун талд	47Т0668917 4804134	8	
9		Их хонгил	47Т0672373 4113335	5	
10		Сумын хойно	470667312 4799181	2	
11		Ямаат уул	47Т0668557 4816447	3	
НИЙТ ДҮН					37

" " < "

№	Байршил	Гадаад орчны үзүүлэлтүүд					Температур, °C
		Салхины дундаж хурд м/сек	Орчны гэрэлтүүлэг, LUX	Чийгшил, %	Гадаад орчны дуу чимээ, dB		
					Бага	их	
1	Баруун сухант	6	1902	24.5	41.7	67.2	25
2	Нүдэн булаг	1.2	1945	23.8	42.1	67.4	28
3	Их хонгил	6.5	1958	20.2	43.5	71.4	31.2
4	Ямаат уул	4.8	1870	18.2	44.1	69.4	26.4



Зураг 51. Судалгааны үед тааралдсан амьтдын байршил

5.4.2 Амьтдын тархалтын талаар мэдээллийн самбар уурхайн орчинд байршуулах

Нарийн сухайтын уурхайн орчимд хар сүүлт, цоохор ирвэс, янгирын мэдээлэл агуулсан 3 ширхэг самбарын эх бэлтгэж, сумаас Шивээ хүрэн боомт явах замд байршуулсан.



Зураг 52. Амьтны мэдээллийн самбар

5.4.3 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

Уурхайн ногоон байгууламжид ургаж байгаа мод, бутны усалгаа арчилгааг тогтмол хийсэн. 2023 оны байдлаар 14 зүйлийн 36,400 ширхэг мод, бут ургаж байна. Нийт 7000 м² талбайг зүлэгжүүлсэн бөгөөд тогтмол арчилж тордож байна.

Хүснэгт 18. Ногоон байгууламжийн тооллого

№	Ногоон байгууламжийн төрөл	Хэмжих нэгж	Ногоон байгууламжийн хэмжээ	Усалгааны төрөл
1	Мод бут	Ширхэг	36,400	Дуслын усалгааны систем
2	Зүлэгжүүлэлт	м ²	7000	Бороожуулагч
3	Мандлын цэцэг	Ширхэг	5000	Бороожуулагч



Зураг 53. Ногоон байгууламжийн өнөөгийн байдал

Уурхайн ногоон байгууламжид 2023 оны байдлаар нийт 7000 м² талбайн зүлэг усалгааг сайжруулах зорилгоор зүлгийн усалгааны системийг мананжуулах усалгааны системээр сольсон. Мөн шинээр зүлэг тайрагч автомат машин авч уурхайн хотхон дундын зүлэг арчилгааг 4-10 дугаар саруудад 2 ээлжээр тогтмол хийж гүйцэтгэж байна.



Зураг 54. Зүлэг усалгааны систем

Хашлага үүсгэх зорилгоор тарьсан хайлаас, бургасны тайралт таналт, хортон шавжаас хамгаалж будах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг тухай бүрд нь хийсэн.



Зураг 55. Ажилчдын хотхонд тарьсан мандалын цэцэг

Хүснэгт 19. 2023 онд нөхөн тарилт хийсэн модны төрөл, тоо хэмжээ

№	Тарьсан байршил	Мод, бутны нэр	Нас	Өндөр /м/	Тоо ширхэг
1	Ажилчдын хотхон	Гүйлс, агч, хайлаас	3	80-100	1520
2	Дунд хотхон	Шар хуайс, гүйлс	3	60-80	450
3	Эх ургамлын талбай	Хайлаас, чацаргана, бургас, харгана	3	60-80	3700
4	Захиргааны зогсоол	Бургас	4	100-120	700
5	Баруун сухант	Гүйлс, агч, сухай	3	80-100	680
6	Баяжуулах үйлдвэр	Бургас	4	100-120	200
7	Шивээ хүрэн боомт	Хайлаас	3	60-80	50
8	Ногоон чулууны булаг	Хайлаас	3	60-80	100
НИЙТ					7400

5.4.4 Зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авах

Зэрлэг ан амьтанд мөс болон өвс тавих био-техникийн арга хэмжээг 2023 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр “Тос тосон бумын нурууны тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа болон, “Монголын Алт” (МАК) ХХК-ийн Нарийн сухайт уурхай, Гурвантэс сумын ЗДТГ-тай хамтран уурхайгаас 50 боодол өвсийг "Зэрлэг амьтдад (Аргаль, янгир, зээр) зориулан биотехникийн арга хэмжээг дараах цэгүүдэд хийж гүйцэтгэсэн (Биотехникийн арга хэмжээний ажлын, төлөвлөгөөтэй файлан 2023 хавсралт 4

1. Хаалга - 43°14'16.69"N, 100°44'19.50"E /10 боодол өвс/
2. Ямаан ус - 43° 8'4.37"N, 100°31'0.41"E /10 Боодол өвс/
3. Дүүжин овоо - 43. 14751°N, 100.40809°E /10 Боодол өвс/
4. Хүүш – 43.14496°N, 100.36314°E /10 Боодол өвс/
5. Гүүт - 43.11308°N, 100.25181°E /10 Боодол өвс/

Хамтран ажилласан хүмүүс:

1. Тос тосон бумын нурууны байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн болон байгаль хамгаалагч нар оролцов.

2. “Монголын Алт” (Мак) ХХК-ний Нарийн сухайтын уурхайн байгаль орчны мэргэжилтэн Ч.Гантуяа, Э. Санжмаа болон туслах ажилтан-3 жолооч-2
3. “Хүрэн толгой коал майнинг” ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн П.Энхбаяр туслах ажилтан-2 жолооч-1 тус тус нийт 18 хүний бүрэлдэхүүнтэйгээр биотехникийн арга хэмжээ авч өвс тэжээлийг байршуулсан



Зураг 56. Өвс ачиж байгаа байдал

Биотехникийн арга хэмжээг 08:00 цагаас 17:35 цагийн хооронд нийт 200 орчим км зам туулж Ажлын хэсэгт багтсан 7 хүний өдрийн цалин болон 320 литр түлш, 50 боодол өвсний зардалд 500000 төгрөг зарцуулсан байна. Ажлын хэсэгт байгаль орчны мэргэжилтэн, Инженер, жолооч болон туслах гэсэн 7 хүн явж Байгаль орчны мэргэжилтэн (ажлын явцад хяналт тавьж тайлан бэлтгэж танилцуулан) ажилласан.

Хүснэгт 20. Биотехникийн арга хэмжээнд нийт зарцуулсан зардал

№	Зарцуулсан зардал	Ажилласан байдал	Нэгж.төг	Дүн
1	Манипуляторт кран	160л	3850	616,000
2	Landcruiser-76	144л	3850	554,400
3	Өвс	50	10000	500,000
4	Ажилтны цалин	7 хүн	157,156	1,100,092
НИЙТ ДҮН				2,770,492

5.4.5 "Биологийн олон янз байдлыг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх

Байгаль орчны тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөний хүрээнд Гурвантэс сумын ерөнхий боловсролын сургуулийн биологийн кабинетыг тохижуулж сурагчдын биологийн хүрээлэн буй орчны талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 10 сарын 17 ний өдөр Гурван тэс сумын ерөнхий боловсролын сургуулийн биологийн танхимд шаардлагатай байгаа 5 сая төгрөгийн үнэ бүхий үзвэр, хичээлийн хэрэглэгдэхүүнүүдийг худалдан авч сургуулийн захиргаанд хүлээлгэн өгсөн.

БОЯБ-г хамгаалах өдрийн хүрээнд Монголын алт (МАК) ХХК-ийн Нарийн сухайтын уурхайгаас Гурвантэс сумын ЕБС-ийн биологийн кабинетийг тохижуулах бараа, материалыг хүлээлгэн өгсөн акт

2023.10.17

Дэлхийн БОЯБ-г хамгаалах өдрийг дэлхий нийтээр жил бүр уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлдэг билээ. БОМТ-ний хүрээнд энэхүү өдрийг тохиолдуулан МАК – Нарийн сухайтын уурхайн зүгээс өмнө онд хийсэн ажлыг үргэжлүүлэн жил бүр уламжлал болгон зохион байгуулан ажиллаж байна. Энэ онд дараах материалуудыг хүлээлгэн өгч байна. Үүнд:

№	Хэрэглэгдэхүүн	Тоо / ш/	Нийт үнэ	Хариуцах байгууллага
1	Ногоон самбар	1	5 сая	МАК
2	Гэрлийн микроскоп	3		
3	Шавьж шахмал	2		
4	Навчны бүтэц	1		
5	Цэцгийн дотоод бүтэц	1		
6	Өндөр, жин хэмжигч	1		
7	Үений бүтэц	1		
8	Хамар, хоолойн бүтэц	1		
9	Шавьж харах сав	4		
10	Загасны араг яс	1		
11	Туулайн араг яс	1		
12	Бэлдэцүүд	1		
13	Олон үйлдэлт принтер	1		
14	Шилэн нүүртэй төмөр шүүгээ	1		
15	Мэлхийн хөгжил	1		
16	Ишний бүтэц	1		
17	Мэлхийний араг яс	1		

Хүлээлгэн өгсөн: Нарийн сухайтын уурхайн
ХАБЭА-н инженер
Байгаль орчны мэргэжилтэн
Байгаль орчны мэргэжилтэн
Хүлээн авсан: Гурвантэс сумын ЕБС-ийн захирал
Биологийн багш
Гурвантэс сумын
Байгаль орчны мэргэжилтэн

Т.Амартүвшин
Э.Сайжмаа
Б.Тэнгис
Г.Базармаа
Л.Түмэнжаргал
А.Бүжин



Зураг 57. Хүлээлгэн өгсөн акт, зураг

ИРВЭС ХАМГААЛАХ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ

Жил бүрийн 10-р сарын 22-ны өдөр уламжлал болгон зохион байгуулагддаг “Олон улсын ирвэс хамгаалах” тэмдэглэл өдөрт зориулж Гурвантэс сумын нутагт орших “Тост, тосон бумбын нуруу”-ны байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаанд 2 ширхэг 2 нүдний дуранг нийгмийн хариуцлагын хүрээнд бэлэглэв.



Зураг 58. Байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаанд дуран хүлээлгэн өгсөн байдал

БҮЛЭГ 6 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

6.1 УУРХАЙН ХАВАР, НАМРЫН МОД ТАРИЛТ

Нарийн Сухайтын уурхай нь анх 2008 он буюу ил уурхайн нүүрс олборлох үйл ажиллагаа эхэлсэн цаг үеэс ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг жил бүр тогтмол зохион байгуулж ирсэн бөгөөд энэ хугацаанд нийт 8,1 га талбайд 14 төрөл зүйлийн 36,400 ширхэг мод тарьж ургуулаад байгаа ба 7000 м² талбайд зүлэгжүүлэлт хийсэн. Мод тарих аянд нэгдсэн гэрээт байгууллагуудыг алдаршуулан тарьсан модыг гэрчилгээ олгов.



Зураг 59. Уурхайн ногоон байгууламж

2023 оны хавар, намар бүх нийтээр мод тарих ажлын хүрээнд эх ургамлын талбай, Баруун сухантын хөв цөөрөм, Шивээ хүрэн боомт, Ногоон чулууны булаг, Баяжуулах үйлдвэр, засвар үйлчилгээний төвийн ойр орчимд 6 төрлийн нийт 7400 ширхэг мод, тарьж уурхайн ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.

Хүснэгт 21. 2023 оны мод тарилтын байршил, мэдээлэл

№	Тарьсан байршил	Мод, бутны нэр	Нас	Өндөр /м/	Тоо ширхэг
1	Ажилчдын хотхон	Гүйлс, агч, хайлаас	3	80-100	1520
2	Дунд хотхон	Шар хуайс, гүйлс	3	60-80	450
3	Эх ургамлын талбай	Хайлаас, чацаргана, бургас, харгана	3	60-80	3700
4	Захиргааны зогсоол	Бургас	4	100-120	700
5	Баруун сухант	Гүйлс, агч, сухай	3	80-100	680
6	Баяжуулах үйлдвэр	Бургас	4	100-120	200

7	Шивээ хүрэн боомт	Хайлаас	3	60-80	50
8	Ногоон чулууны булаг	Хайлаас	3	60-80	100
НИЙТ					7400

Эх ургамлын талбайд хамгаалалтын зурвас байдлаар тарилт хийсэн



Ажилчдын хотхон



Засвар үйлчилгээний төв



Зураг 60. Мод үржүүлгийн талбай болон уурхайн бусад байршилд мод тарьсан байдал




Зураг 61. Мод тарих аянд нэгдсэн гэрээт байгууллагад гэрчилгээ олгосон

Мод үржүүлгийн талбайд үрсэлгээ хийх, нөхөн тарилтад гаргах болоогүй байгаа суулгацуудын арчилгаа усалгааг тогтмол хийх

Мод үржүүлгийн талбайд хайлаас, заг, жигд, бургас, сухай, улиас, гүйлс, агч, голт бор, чацаргана, жигд, харгана зэргийг суулгацаар тарьж ургуулах, туршилт судалгаа тогтмол хийж байна.

2023 онд уурхайн эх ургамлын талбайд үрээр тарилт хийж, бойжуулах зориулалтаар 6x20 харьцаатай зуны хүлэмжийг барьж ашиглалтад оруулсан. Хүлэмжид үрээр жигд, гүйлс тарьж туршилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 62. Зуны хүлэмжид тарилт хийж буй байдал


Усалгааны системийн засвар хийж, шинээр тарилт хийсэн талбайд 500 м урттай, 500 мм диаметртэй усалгааны хоолойг татаж, 10 мм диаметртэй дуслын усалгааны системийг мод бүрд байрлуулж усалгаа, арчилгааг тогтмол хийж гүйцэтгэсэн.

Мод үржүүлгийн талбайд салхины хашлага ургамал хийх зорилгоор 2-3 настай 0.5 м - 0.8 м өндөртэй 1000 ш хайлаас , 700 ш харгана, 500 ш чацаргана, 100 ш гүйлс, голт бор, агч зэргийг шинээр тарьж суулгацуудын тоог нэмэгдүүлж, бойжуулахаар ажиллаж байна.

6.2 Мод үржүүлгийн талбайн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх

Уурхайн нөхөн сэргээлт мод үржүүлэгт зарцуулагдах зардлыг бууруулах, тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутаг, яам, засгийн газраас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх дотоод нөөц үүсгэх, уурхайн төслийн талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор мод үржүүлгийн газрын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулахаар “Их говийн төгөл” ХХК-тай 2023 оны 9-р сард зөвлөх үйлчилгээг авах нэг жилийн хугацаатай гэрээ байгуулан, хамтран ажиллаж байна (*Их говийн төгөл ХХК ажил*). *гүйцэтгэх гэрээ*

2023 оны X/11-13 өдрүүдэд Нарийн Сухайтын уурхайн ногоон байгууламжтай газар дээр нь танилцаж, зөвлөгөө өгсөн ба Мод үржүүлгийн газрыг өргөжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө боловсруулахаар ажиллаж байна (*Мод үржүүлгийн газрын гэрээт бай*
хавсралт 9



Зураг 63. Гэрээт компанийн төлөвлөгөө

6.3 ХААЛТЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН САНХҮҮГИЙН ТООЦООЛОЛ

Asset retirement obligations (ARO) буюу хаалтын нөхөн сэргээлтийн санхүүгийн тооцооллын гол зорилго нь уурхайн үйл ажиллагаа, дэд бүтцийн барилга байгууламжтай холбоотой эвдэрсэн хөрсөн бүрхэвч, нөлөөлөлд өртсөн тухайн газрыг байгалийн унаган төрхөд дөхүүлэн нөхөн сэргээх, барилга байгууламжийг буулгах, шилжүүлэн ачих зэрэгт шаардагдах зардлыг Монгол болон олон улсад мөрдөгдөж байгаа хууль дүрэм, стандартыг удирдамж болгон тооцоолон гаргахад оршдог. Мөн уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүд нь тухайн газар нутгийн амьдрах орчны аюулгүй байдлыг бүрэн хангаж, хэвийн нөхцөлд шилжүүлэхэд чиглэсэн байдаг (ARO х а а л т ы н н ө х ө н с э р г э э л л т и й н с а н х ү ү г и й н т о о ц о о л о л 2 0 2 3). у х а в с р а л т 5


Энэ ажлын хүрээнд уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн санхүүгийн тооцоолол гүйцэтгүүлэхээр 2022 оны 9 сараас эхлэн “Грийнтрендс” ХХК- тай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус ажлыг гүйцэтгэхэд 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн УУХҮ-ийн сайд, БОАЖС-ын А/181, А/458 тоот хамтарсан тушаалаар баталсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”, нөхөн сэргээлтийн аргачлал болон олон улсын санхүү, нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдлөг болгосон (Г р и й н т р е н д с Х Х К а г ү й ц э т г э х г э р . э э х а в с р а л т 1 2



Зураг 64 . Нөхөн сэргээлтийн санхүүгийн тооцоолол мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн гэрээ

Зөвлөх компани уурхайн талбай дээр ажиллаж нийт 217 хөндөлтөд өртсөн, унаган төрхөө алдсан газрыг бүртгэж, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө урьдчилан боловсруулсан.

Уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг илүү бодитой учирзүйн ач холбогдолтой байх дээр онцгойлон анхаарч байгаа бөгөөд уурхайн тодорхой хэсэг газарт ногоон байгууламж бий болгох, зарим барилга байгууламжийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн цаашид ашиглах, дэд бүтцийн байгууламжийг орон нутагт хүлээлгэн өгөх, монгол улсад мөрдөгдөж байгаа нөхөн сэргээлтийн аргачлал болон талбайн нөхцөл байдлын харгалзан ухаш овоолгын нөхөн сэргээлтийн урьдчилсан тооцоог гаргасан.




Зураг 65. Ажлын явц болон урьдчилсан байдлаар гаргасан нийт эвдэрсэн газрын тоо

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-д нөхөн сэргээлтийн чиглэлүүдийг зааж өгсөн байдаг. Урьдчилсан байдлаар нийт эвдэрсэн 217 газрыг амралт сувилал, барилга байгууламж, ойн аж ахуй, хөдөө аж ахуй бэлчээрийн чиглэлээр нөхөн сэргээхээр төлөвлөөд байна.


Хөдөө аж ахуй, бэлчээрийн зориулалтаар нөхөн сэргээх эвдэрсэн газарт уурхайлалтын хэсгийн томоохон объект болон ухаш, хоосон хөрсний овоолго хамаарч байгаа бөгөөд ухаш, хоосон хөрсний овоолгын эзлэхүүн тооцооллод геологи, уул уурхайн төлөвлөлтийн программ хангамж болох Hexagon MinePlan-ыг, налуугийн тогтворжилтыг Rocscience Slide програмуудыг ашиглан нөхөн сэргээлтийн уулын ажлын тооцоог гүйцэтгүүлсэн.

Доорх зураг 57, 58-д хоосон хөрсний 5-р овоолгын нөхөн сэргээлтийн өмнөх болон нөхөн сэргээлтийн дараах хэлбэржүүлэлтийн байдлыг, нийт уулын хэсгийн нөхөн сэргээлтийн дараах налуужилтыг 3D зургаар жишээ болгон харуулав. Зургаас хэлбэржүүлэлтийн дараа хоосон хөрсний овоолгын суурь тэлсэн, илүү налуу болсныг харж болно.



Зураг 66. Хөрсний овоолгыг тооцооллыг дагуу техникийн нөхөн сэргээлт хийсний дараах байдал

Нөхөн сэргээлт хийсний дараагаар гадаргуудын налуужилт илүү намссан буюу 2 дахь зурагт тод ягаанаар хүрээлэгдсэн талбайн хэмжээ нэмэгдсэн, эгц босоо хэсэг буюу ногоон, улаанаар тэмдэглэгдсэн газар багассан байгааг харж болох юм.



Зураг 67. Хөрсний овоолгыг тооцооллыг дагуу техникийн нөхөн сэргээлт хийсний дараах байдал

Энэхүү уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн урьдчилсан төлөвлөгөө, тооцооллыг манай компани цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэж явах ба уурхайн нөхөн сэргээлтийг илүү бодитой, төлөвлөгөөтэй гүйцэтгэхээр зорин ажиллаж байна.

6.4 ХООЛ, ХҮНСНИЙ ХАЯГДАЛ, ТАХИАНЫ САНГАСААР БОРДОО БЭЛТГЭЖ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЛБАЙД ТУРШИХ

Уурхайн гал тогооноос гарч байгаа хүнсний ногооны хаягдал, амны сальфеткан цаас, өндөгний хальс, цайны идээ, дүрдэг цай зэргийг ашиглан 10 кг компост бордоог туршилтаар бэлтгэж, уурхайн тасалгааны цэцэг, модонд нэмэлт бордоо болгон ашиглалаа.

Мөн бусад компанийн бэлтгэн нийлүүлж байгаа бордоонуудтай харьцуулан туршилтын ажил хийв.



Зураг 68. Компост бордоо бэлтгэх үйл явц

6.5 ШИМТ ХӨРСНИЙ ҮРЖИЛ ШИМИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР ОЛОН НАСТ ТАРИХ

Уурхайн газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулах, хадгалах MNS 5916:2008 стандартын дагуу шимт хөрсийг зориулалтын талбайд хэлбэржүүлэн хадгалж байна (*х а в с р а л т 23*).

2023 онд шимт хөрсний № 4 овоолгын хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх зорилгоор төлөвлөгөө гарган дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ. Үүнд:

Шимт хөрсний №4 овоолгыг стандартын дагуу хэлбэржүүлэн, 1:1.5м хэмжээтэй самбар байрлуулж, олон наст өвслөг ургамал болох царгас, хүцэнгэ, өлөнгө зэргийг үрээр тарьж, 2-3 настай 50 ширхэг жигд, хайлаасыг шилжүүлэн тарьж нийт 0,74 га талбайд 10 тонны ёмкостиг байршуулж, зөөврийн усаар цэнэглэн, 200 м автомат усалгааны системд холболт хийж, усалгаа арчилгааг ургамал ургалтын хугацаанд тогтмол хийж ажиллалаа.

БАТЛАВ.УУРХАЙН ДАРГА *Ц.ЦОЛМОНБАЯР*

Шимт хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх
ажлын төлөвлөгөө

2023.05.11

Үндэслэл


БОННУ, "Байгаль орчны хамгаалах тухай хууль"-д шимт хөрсний овоолгуудыг уурхайн хөрс хуулалтаас үүссэн шимт хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх тухай заасны дагуу 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нөхөн сэргээлт хэсэгт тусгаж, шимт хөрсний стандартын дагуу техникийн нөхөн сэргээлт хийж, олон наст ургамал тарьж хадгалалтыг сайжруулах.

Зорилго

MNS 5916:2008 стандартын дагуу 5м ийн өндөртэй 2-6 градусын налуутай 1 га талбайг шимт хөрсний 4-р овоолгын баруун талд төлөвлөж, хэлбэржүүлнэ.

Зорилт

- Стандартын дагуу хэлбэржүүлсэн шимт хөрсний овоолго үүсгэх
- Олон наст өвслөг ургамал тарьж, үржил шимт байдлыг хадгалах



Зураг 1. Шимт хөрсний 4-р овоолгын байршил

Хүснэгт 1. Нөхөн сэргээлтийн хүрээнд хийх ажлууд

№	Хийх ажлууд	Хугацаа	Хамтран ажиллах хэсэг	Хяналт тавьж ажиллах
Бэлтгэл ажлууд				
1	Стандартын хэлбэржүүлэх дагуу	V.17	УХ, ТХ	Байгаль орчны мэргэжилтэн
2	Самбар байрлуулах	V.25	УХ	
3	Усалгааны систем засварлах	V.18 V.20	УХ, ААХ	
Олон наст ургамал тариалах явц				
6	Үр захиалах / царгас /	VI.01	ЗХНХ – Хангамжийн мэргэжилтэн	Байгаль орчны мэргэжилтэн
7	Талбай, хөрс бэлтгэх	V.15 V.17	ААХ – Галч, усалгаачин	
8	Тарилт хийх хугацаа	VI.02 VI.04		
9	Ажиглалт судалгаа хийх	VI.02 X.01		
10	Туршилтын ажлын тайлан танилцуулах	X.05		

Боловсруулсан:

Байгаль орчны мэргэжилтэн

Э.Санжмаа

Э.Санжмаа

Танилцсан:

Орлогч дарга


П.Зоригоо

П.Зоригоо


ХАБЭАБОХ – ийн дарга

Э.Билгүүн

Э.Билгүүн - 2



Зураг 69. Шимт хөрсний №4 овоолгод хийх ажлын батлагдсан төлөвлөгөө



Зураг 70. Төлөвлөгөөний дагуу хэлбэржүүлж, зүлэг тарьсан байдал

6.6 ХӨРШ ЗЭРГЭЛДЭЭХ УУРХАЙНУУДТАЙ ХАМТРАН ГУРВАНТЭС СУМЫН ТӨВД БАЙГУУЛСАН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГ ӨРГӨЖҮҮЛЭХ

Нарийн Сухайтын нүүрсний бүлэг орд газарт үйл ажиллагаа явуулж буй "Монголын Алт" (МАК) ХХК, "Хүрэн толгой коал майнинг" ХХК, "Өсөх зоос" ХХК, "Саус гоби сэнде" ХХК хамтран Гурвантэс сумын "Суваргатай талбай" –д тохижилтын ажлыг 2020 оноос эхлэн хийж гүйцэтгэн, ажиллаж байна.

БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

7.1 УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ БОЛЖ, ШАТ ДАРААЛАН АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАХ

Уурхайн БОННУ – нд тодотгол хийгдэж байгаатай холбоотой дүйцүүлэн хамгаалах ажлын урт болон дунд хугацаанд төлөвлөгөө гарган, үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч ТЭЗҮ-г ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх хуваарь, ТЭЗҮ батлагдсан тогтоол батлагдах үе шат удааширч, хүлээгдсэнээс Байгаль орчны үнэлгээг боловсруулах ажил хойшлогдсон хэдий ч манай уурхайн зүгээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Өмнөговь аймгийн БОАЖГ-аас өгсөн зөвлөмж чиглэлийн дагуу дунд болон урт хугацааны Дүйцүүлэх хамгаалах төлөвлөгөө гаргахаар 8 сард Грийнтрэндс зөвлөх компанитай уулзалт хийж уурхайн зүгээс саналаа танилцуулж, зөвлөлдсөн.
- Үүний дараа зөвлөх компаниас холбогдох судалгааг гүйцэтгэж дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөг боловсруулан ирүүлсэн.

НЭГ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТУХАЙ СУМ ОЙЛГОЛТ

1.1. Хууль эрх зүйн зохицуулалт

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах талаар

БОННУ-ий тухай хуулийн 3.1.11-д "биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах" гэдг төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ" гэж тодорхойлсон. Мөн хуулийн 8. "Газрын тос, үүл уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлд хаалтын ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлийн зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцү хамгааллын арга хэмжээ" хэрэгжүүлэх гэж, 9.6-д "Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд бай орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцү хамгаалах хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна" гэ тус заасан.

Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсрал батлагдсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журамд дүйцүүлэн хамгаалах да шаардлагуудыг заасан. Үүнд:

- 5.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамга арга хэмжээг тусгах ба дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь дараах зарчмыг хангасан байна;
 - 5.2.1. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх газар нь тухайн нөлөөлөлд өртсөн газартай байгаль экологийн нөхцөлтэй байх;
 - 5.2.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардлын тооцоо нь үнэн бодит судалгаа, мэдээ үндэслэсэн байх;
 - 5.2.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс хуулиар хүлээсэн нөлөөл бууруулах, арилгах, нөхөн сэргээх үүргээс зайлсхийх нөхцөл болохгүй байх;
 - 5.2.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, үр дүнг тайлагнах хэлбэр, хя тавих механизм зэргийг тодорхой тусгасан байх гэсэн заалтууд байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам

